

Уул уурхайн татварууд

Оюу Толгойн хэрэг ба Рио Тинтогийн Монгол дахь татвар зувчуулалт



Монгол улс

Винсент Кизебринк, Роданте Алерс, Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл

2018 оны 1 дүгээр сар

Colophon

Уул уурхайн татварууд

Оюу Толгойн хэрэг ба Рио Тинтогийн Монгол дахь татвар зувчуулалт
Амстердам, 2018 оны 1 дүгээр сар

Authors: Vincent Kiezebrink (SOMO),
Rhodante Ahlers (SOMO) &
Sukhgerel Dugersuren (OT Watch)
Layout: Frans Schupp
Cover photo: iStock.com/eyegelb
ISBN: 978-94-6207-130-8

This publication is made possible with financial assistance from The Dutch Ministry of Foreign Affairs. The content of this publication is the sole responsibility of SOMO and can in no way be taken to reflect the views of The Dutch Ministry of Foreign Affairs.



Oyu Tolgoi Watch

Ulaanbaatar, 46A Mongolia
T: 976-98905828

Oyu Tolgoi Watch is a non-profit, non-governmental organization established in 2009 to monitor Oyu Tolgoi project's compliance with the international environmental and human rights norms and standards. OT Watch was established by a group of CSOs which have actively engaged with government and protested against signing the unfair investment agreement. Since its establishment OT Watch is working in partnership with national, international civil society networks in advocating for fair and accountable mining and investment practices respectful of human rights in the development process.



Stichting Onderzoek Multinationale
Ondernemingen
Centre for Research on Multinational
Corporations

Sarphatistraat 30
1018 GL Amsterdam
The Netherlands
T: +31 (0)20 639 12 91
F: +31 (0)20 639 13 21
info@somo.nl
www.somo.nl

The Centre for Research on Multinational Corporations (SOMO) is an independent, not-for-profit research and network organisation working on social, ecological and economic issues related to sustainable development. Since 1973, the organisation investigates multinational corporations and the consequences of their activities for people and the environment around the world.



Уул уурхайн татварууд

**Оюу Толгойн хэрэг ба Рио Тинтогийн Монгол дахь
татвар зувчуулалт**

SOMO, ОЮУ ТОЛГОЙН ХЯНАЛТ ТББ

Винсент Кизебринк, Роданте Алерс, Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл

Амстердам, 2018 оны 1 дүгээр сар

ГАРЧИГ

Тайлангийн хураангуй	3
1 Оршил	6
1.1 Монгол улсын хувьд Оюу Толгойн ач холбогдол	7
1.2 Илтгэлийн сэдэв болон шинээр гарах нийтлэлүүд	9
1.3 Аргачлал.....	10
2 Оюу толгойн уурхай	11
2.1 Оюу Толгойн хайгуул ба уурхайн хөгжил	11
2.2 Оюу Толгойн нийгэм, байгаль орчны нөлөөлөл	12
2.3 Оюу Толгойн компанийн өмчлөлийн бүтэц.....	14
2.4 Санхүүжилт.....	18
3 Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ	20
3.1 Гурван тал Татварыг тогтворжуулав уу? Аль эсвэл тусгаар улсын бүрэн эрхээс татгалзав уу?.....	20
3.2 Орлого тойрсон маргаан – Монгол улс бууж өгөв	22
3.3 Оюу Толгойн хэлэлцээн дэх МУ-ын Засгийн газрын үүрэг оролцоо	24
4 Татвараас зайлсхийх ба татварыг хэт бууруулах нь	26
4.1 Люксембургээс ирэх зээл	26
4.2 Люксембург дахь татварын тохиролцоо: Канадын татвараас зайлсхийх нь.....	31
4.3 Оюу Толгойн зүй бус Хөрөнгө оруулалтын гэрээ: Монголд төлөх татварын үүргийг бууруулах нь	33
4.4 Нийт татварын алдагдал	39
5 Нидерланд дахь “шуудангийн хайрцаг” компанийг дөрөөлсөн гэрээний урвуулан ашиглалт	40
6 Дүгнэлт	42
6.1 Зөвлөмжүүд	47

Тайлангийн хураангуй

улсын Өмнөговь аймагт орших Оюу Толгой уурхай Монголын зэс ба алтны тэргүүлэх уурхай юм. Уурхайн чухам эзэн хийгээд олборлолтыг гүйцэтгэгч нь татварын диваажингуудад бүртгэлтэй олон охин компани бүхий өмчлөлийн бүтцээрээ дамжуулан хяналтаа тавьж захирдаг Рио Тинто юм.¹ МУ-ын Засгийн газар Оюу Толгой уурхайд цөөнх буюу 34%-ийн эзэмшилтэй. Рио Тинто МУ-ын Засгийн газарт ашиг сонирхолд нь нийцэхгүй гэрээ хэлцэлүүдийг шахан гарын үсгийг нь тавиулж чадсан ба ингэснээрээ Монгол, Канадад төлөх үлэмж хэмжээний татвар төлөлтөөс байнга зайлсхийх боломж бүхий татвараас бултах тогтолцоог бий болгон хамгаалж ирсэн тухай энэхүү илтгэлд өгүүлэх болно.


2013 онд эрдсийн эхний хүдрийг олборлож эхэлсэн ил уурхай буюу Оюу Толгойн нэгдүгээр шатны барилгын ажил болонүйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд Рио Тинто нь Нидерланд, Люксембург зэрэг дэлхийг толгойлсон татварын диваажингуудыг оролцуулсан татвараас зайлсхийх тогтолцоог хэрэглэсэн аж.² Уг тогтолцооны хүрээнд 6 тэрбум гаран ам.долларыг Люксембургд бүртгэлтэй, “шуудангийн хайрцаг” төдий компанидаа оруулж, тэндээс Оюу Толгой руу шилжүүлсэн нь доорх схем дээр тодорхой харагдана. Рио Тинто барилгын ажил болон уурхайн олборлолтыг дангаараа санхүүжүүлж, Монголын талын 34% эзэмшлийг санхүүжүүлэх зээлийг МУ-ын Засгийн газарт олгожээ. Энэхүү зээл нь Лондонгийн Банк хоорондын санал болгох хүү (LIBOR) дээр 6.5% нэмсэн суурьтай байхаар тохирч, МУ-ын Засгийн газар аливаа ашиг хүртэхээс өмнө зээлээ бүрэн гүйцэд эргэн төлсөн байна гэж зээлийн нөхцөлд тодорхойлсон байдаг.

2013 онд МУ-ын Засгийн газар ОУВС-ийн зөвлөмжийн дагуу Рио Тинтогийн татвараас зайлсхийх боломжийг хаах зорилгоор Нидерланд болон Люксембургтэй хийсэн давхар татварын хэлэлцээрүүдийг цуцлахад Оюу Толгойн төслийн Хөрөнгө оруулалтын гэрээнд “татварыг тогтворжуулсан” учраас Рио Тинтогийн төлөх татварын хэмжээ нэмэгдэхгүй гэж хэвлэлийн төлөөлөгч нь мэдэгдсэн байдаг. Татварын гэрээнүүдэд татварын хөнгөлөлтийг 2009 оны түвшинд тогтворжуулах – буюу царцаах – талаар тохирсноор МУ-ын Засгийн газар үндсэндээ татварыг тодорхойлон ногдуулах бүрэн эрхээсээ татгалзсан байна.

Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд татвар тогтворжуулах заалтыг суулгаж өгсөний улмаас Рио Тинто нь 2013 онд Монголын ЗГ-ын шийдвэрээр цуцлагдсан татвараас чөлөөлөх дээрх гэрээнүүдийн давуу талыг үргэлжлэн ашиглах боломжтойгоо үлдсэн юм. Эдгээр (цуцлагдсан) давхар татварын гэрээ нь Оюу Толгойгоос гадаад дахь бусад компанид төлөх хүүний суутгал татварыг 20%-иас 10% болгон бууруулсан байдаг бөгөөд энэхүү хөнгөлөлтийг Рио Тинто нь Нидерланд, Люксембург-д бүртгэлтэй “шуудангийн хайрцаг” хэмээх хэлбэр

1 Энэхүү охин компаниуд Нидерланд, Британийн Виргинийн арлууд, Делөвер, Аруба-д байршдаг.

2 <https://www.oxfam.org/en/shining-light-tax-havens-eu-cant-ignore> Оксфам Интернэшнл, “Хар жагсаалт уу? Эсвэл халхавч үү? ЕХ-ны татварын диваажингийн үнэн бодит хар жагсаалт ямар байхын тухайд” (Blacklist or whitewash? What a real EU blacklist of tax havens should look like), 2017-11-27. <https://www.oxfam.org/en/research/blacklist-or-whitewash-what-real-eu-blacklist-tax-havens-should-look>. Авсан 2017-12-08.



төдий охин компаниудараа дамжуулан эдэлсээр иржээ. Гэтэл “шуудангийн хайрцаг” гэгч компаниудыг ашиглах замаар давхар татвараас чөлөөлөх хэлэлцээрт тусгасан аливаа давуу талыг хууль бусаар хүртэх явдлыг Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (OECD) нь гэрээний урвуулан ашиглалт гэж тодорхойлсон аж.³

Оюу Толгойгоос орж буй орлогоос хүртэх хувиа өсгөх оролдлогыг МУ-ын Засгийн газар удаа дараа хийсэн боловч онцын үр дүнд хүрч байгаагүй. Ийм оролдлогыг 2012 онд Оюу Толгойн үйл ажиллагаанаас орсон орлогоос нэмэлт \$300 сая татварыг баталгаажуулах оролдлого хийсэн. 2015 он гэхэд 1700 хүнийг ажлаас нь халж, Оюу Толгой төслийн төлөвлөгдсөн өргөтгөлийг хойшлуулах зэргийн Рио Тинтогийн шахалтад орсон Засгийн газар буулт хийж, өмнө нь нэхэж шаардсан татварынхаа багахан хувийг авсан байдаг.

Оюу Толгойн ашгийг хуваарилах асуудлаар Рио Тинто, МУ-ын Засгийн газрын хооронд үүссэн маргаан 2015 онд шийдвэрлэгдсэний дараагаар Рио Тинтогоос Нидерланд болон

Люксембург дэх компаниуддаа шилжүүлэх хүүний орлогоос МУ-ын авах татвар 10%-иас бүр 6.6% болж буурсан байдаг. Энэхүү буурсан татварын хэмжээг ямар нэгэн учир бүхий үндэслэлгүйгээр гадаад оронд төлөгдөх хүүнд ногдох өнгөрсөн хугацааны татварт буцаан хэрэглэсэн байдаг. Талууд маргаанаа шийдвэрлэсэн ба Рио Тинтогоос Монголд төлөх татварын хэмжээ улам буурсан хоёр үйл явдал давхцсан нь хэлцлийн явцад МУ-ын Засгийн газраас Рио Тинтод хийсэн буулт бололтой гэсэн таамаг байна. Давхар татварын гэрээний ашиглалт болон татварын түвшинг буулгаснаар **Рио Тинто Монгол улсад төлөх татвараас \$232 саяыг зувчуулж чадсан байна**. Өнөөгийн бүсээ чангалах нөхцлийг хэрэгжүүлж буй Монгол улсад⁴ энэ орлого ихээхэн тус болох байсан аж. Жишээлбэл, Монголын Засгийн газар ойрын жилүүдэд боловсрол ба эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах төсвөө хоёр дахин нэмэгдүүлэх боломж байжээ.

3 ЭЗХАХБ, Хэлэлцээрийн давуу талыг зүй бус нөхцөлд ашиглахаас сэргийлэх нь – 2015 оны эцсийн тайлан, Арга хэмжээ 6. 2015-10-05 <http://www.oecd.org/tax/preventing-the-granting-of-treaty-benefits-in-inappropriate-circumstances-action-6-2015-final-report-9789264241695-en.htm>.

4 Блумберг, Монгол ОУВС-аас 5.5 тэрбум ам. долларын дампуурлаас сэргийлэх зээл авахад учирсан саад тотгоруудыг арилгав 2017-04-20 <https://www.bloomberg.com/news/articles/2017-04-19/mongolia-clears-hurdles-needed-for-5-5-billion-imf-led-bailout>. Авсан 2017-12-08.

Канад улсад төлөх татвараас зайлсхийх хүсэлд хөтлөгдөн ганц ч ажилтангүй Люксембург улсад шуудангийн хайрцагны бүртгэлтэй компанийг ашиглан Оюу Толгойн үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна. Рио Тинто нь уул уурхайн дорвитой салбаргүй Люксембургд өөр ямар нэгэн холбоо байхгүй бололтой. Санхүү татварын талын асуудлыг үл харгалзвал Канад дахь охин компани буюу Оюу Толгойн хяналтыг атгасан Түркойз хиллзыг ашиглах нь логикийн хувьд Оюу Толгойн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд илүү боломжтой сонголт байх байсан. Гэтэл Люксембургд бүртгэлтэй Мовель охин компанийг ашигласнаар Рио Тинто Канад улсад төлөх компанийн орлогын татвараас \$559 орчим сая долларыг зувчуулсан байна. Люксембург улсад тус компани нь \$2.1 тэрбум долларын татварын өмнөх орлогоос зөвхөн \$89 саяыг төлснөөр бодит татварын дундаж хэмжээг 4.19%-д хүргэжээ. Энэхүү татвараас зайлхийх тогтолцоо нь **Рио Тинтод Канадад төлөх татвараас цэвэр \$470 саяыг зувчуулах боломж олгожээ.**

Зургаан жилийн хугацаанд (2011–2016) Рио Тинто нь Оюу Толгойн эхний шатны үйл ажиллагаанаас Монгол ба Канад улсуудад төлөх олон зуун сая долларын татвараас зайлсхийж чаджээ. Уурхайн хоёрдугаар шатны ажил эхэлж нэмэлт 4,4 тэрбум ам.долларын нийтээс нээлттэй босгосон санхүүгийн багцаар⁵ хэрэгжиж байгаа нь нийтийн өмчийн мөнгө татвараас зайлсхийх тогтолцоогоор дамжиж байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Рио Тинто Оюу Толгойн хөрөнгө оруулалтын нөхцөлүүдийг МУ-ын Засгийн газраар хүлээн зөвшөөрүүлж чадсанаар хүү тооцогдох зээлээр хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, уурхайн ашигт Монгол болон Канадад бус, харин Люксембургд маш бага хувь хэмжээгээр татвар ногдуулах, түүнчлэн Оюу Толгойн зээл эргэн төлөгдөх цаг хугацаагаар орлого хойшлох улмаас МУ-ын Засгийн газар хоосон хоцрох нөхцөл бүрдээд байгаа юм. Оюу Толгойн эзэмшигч компаниуд нэг талаас, нөгөө талаас МУ-ын Засгийн газар хоорондын Хөрөнгө оруулалтын гэрээний үйл явц, агуулгыг нь маш хүч түрэмгийлсэн хэмээнээр тодорхойлж болно. Суутгал татварыг олон дахин бууруулсан нь Засгийн газар уурхайгаас авах орлогыг үлэмж хэмжээгээр танасан бол Оюу Толгойн зээлд төлөх хүү нь уурхайн ашигт ажиллагаа болон Монгол улсын хүртэхээр хүлээж буй ногдол ашгийг бас л хязгаарлах өндөр магадлалтай юм. Иймээс Монголын ард түмэн Оюу Толгойн уурхайгаас ихээхэн үр өгөөж хүртэх эсэх нь эргэлзээ төрүүлж байна.

5 Үүнд хэрэгцээтэй санхүүжилтийг төрийн буюу нийтийн санхүүгийн тогтолцоонд багтах Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК/IFC), Нидерландын хөгжлийн банк (FMO), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ/EBRD), Хөрөнгө оруулалтын баталгааны олон талт агентлаг (ХОБОТА/MIGA), Канадын экспортын хөгжлийн агентлаг (Export Development Canada), Австралийн экспортын санхүү, даатгалын корпорац (Australian Export Finance & Insurance Corp), АНУ-ын Экспорт-импортын банк (Export-Import Bank of the United States of America).

1 Оршил

“Оюу Толгойн цар хүрээг харгалзан аюулгүй, өрсөлдөх чадвар бүхий аж ахуйг байгуулах нь Монгол улсын хөгжил, ард түмний дэгжил мандалд хувь нэмэрлэх боломжийг бий болгоно... Энэхүү төслийн түнш, сонирхол бүхий талууд байгалийн баялгаас алзашгүй үнэт зүйлс, мэдлэг, чадавхийг бүтээх Оюу Толгойн үзэл баримтлалд тулгуурлан Монголын хөгжил дэвшилд хувь нэмэрлэсэн аюулгүй, дэлхийд өрсөлдөх чадвартай зэсийн бизнесийг бий болгохыг эрмэлзэж байна.”

- Рио Тинто⁶

Говийн өмнөд хэсэгт байршилтай Оюу Толгойн уурхай нь Монголын зэс, алтны тэргүүлэх уурхай юм. Дэлхийд томоохонд тооцогдох зэс, алтны нөөцтэй төдийгүй уул уурхай, металлын үйлдвэрлэлийн түүхэнд нийтийн санхүүжилтийн хамгийн том гэрээгээр санхүүжих аж.⁷ Ил, далд уурхайн аль аль нь ашиглалтад ороход ОТ нь 2020 он гэхэд Монголын ДНБ-ний 25–30 хувийг бүрдүүлэх тооцоотой.⁸ Уурхай нь 2013 онд үйлдвэрлэлийнхээ эхний жилд 77,000 тонн зэс, бараг 4,500 кг алт үйлдвэрлэж,⁹ 2016 онд тус тус 201,300 тонн, 8,505 кг-д хүргэсэн байна.¹⁰ Оюу Толгой олборлож гаргасан энэ зэс, алтыг 2016 оны дундаж үнээр тооцолвол 979 сая болон 342 сая ам доллар тус тус болж байгаа юм.¹¹ Бүх бүтээгдэхүүнийг 2017 оны байдлаар дэлхийн хамгийн том зэс хэрэглэгч, алт худалдан авагч болох Хятад улс руу экспортложээ.¹² ОТ уурхайн үйл ажиллагааг Оюу Толгой ХХК хариуцдаг ба түүний 66%-ийг Түркойз Хилл Ресурс өмчилж, үлдэх 34% нь Эрдэнэс Оюу Толгой төрийн өмчит компанийн мэдэлд байна. Харин Түркойз Хилл Ресурс компани нь Торонто болон Нью Йоркийн хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжигддаг ба

-
- 6 Рио Тинтогийн вэб хуудас, Оюу Толгой, огноогүй <http://www.riotinto.com/copperanddiamonds/oyu-tolgoi-4025.aspx>. Авсан 2017-12-27.
 - 7 ОУВС, <http://www.imf.org/external/pubs/ft/scri/2010/cr10166.pdf>; АФП, <https://www.theguardian.com/global/2015/may/19/rio-tinto-and-mongolia-sign-multibillion-dollar-deal-on-mine-expansion>. Авсан 2017-04-04.
 - 8 Түркойз хилл ресурс, Гуравт бичигдэх зэсийн уурхайг ажлуулж эхэллээ <http://www.turquoisehill.com/i/pdf/ppt/Scotia-Conference-Presentation2016.pdf>; Мөн <http://www.mining-technology.com/features/featuresearching-for-another-oyu-tolgoi-mongolias-big-mining-expansion-5805870/>; Олборлох салбааны ил тод байдлын санаачлага 2016, Тойм, Монгол Улс. Extractives Industry Transparency Initiative. (2016). Overview, Mongolia. <https://eiti.org/Mongolia-g-uzne-yy>. Авсан 2017-04-04.
 - 9 Рио Тинто, Жилийн тайлан 2013, http://www.riotinto.com/annualreport2013/_pdfs/rio-tinto-2013-annual-report.pdf (2014-07-18). http://www.turquoisehill.com/s/news_releases.asp?ReportID=742911.
 - 10 Рио Тинто, Жилийн тайлан 2016: Үйлдвэрлэл, нөөц ба үйл ажиллагаа, огноогүй http://www.riotinto.com/documents/RT_AR2016_Production_reserves_operations.pdf, Авсан 2017-12-27. Түркойз хилл ресурс Жилийн тайлан 2016 <http://www.turquoisehill.com/i/pdf/turquoise-hill-ar-FINAL.pdf>. Авсан 2017-12-27.
 - 11 Уг тооцоог гаргахад хэрэглэсэн зэс, алтны дундаж үнийг дараах сайтуудаас олж болно: <https://www.statista.com/statistics/533292/average-price-of-copper/> 2009–2017 онуудын зэсийн жилийн дундаж үнэ (1 тонны үнэ ам. доллараар), огноогүй <https://www.statista.com/statistics/268027/change-in-gold-price-since-1990/> 1990–2017 онуудын алтны жилийн дундаж үнэ (1 трой үнцийн үнэ ам. доллараар), огноогүй.
 - 12 Эдийн засгийн ажиглалтын төв, Монгол улс нь зэсийн хүдрээ хааш нь экспортолдог вэ? (Observatory of Economic Complexity, Where does Mongolia export copper ore to?) 2016, огноогүй https://atlas.media.mit.edu/en/visualize/tree_map/hs92/export/mng/show/2603/2016/, Рио Тинтогийн вэб хуудас, Оюу Толгой, огноогүй <http://www.riotinto.com/copperanddiamonds/oyu-tolgoi-4025.aspx>, <http://ot.mn/exports/>, Оюу Толгой, Экспорт, огноогүй (Oyu Tolgoi, Exports), <http://ot.mn/exports/>, retrieved 27 December 2017. Авсан 2017-12-27.

түүний 51% нь Рио Тинто компанийн өмчинд байдаг юм.¹³ ОТ болон түүнийг ажиллуулагч Рио Тинто нь Монголын байгалийн баялгийн бодлогод голлох үүрэг гүйцэтгэх болсон тул түүнд олон нийтийн хяналтыг чангатгах шаардлага олонтаа тавигдах болсон аж.

1.1 Монгол улсын хувьд Оюу Толгойн ач холбогдол

ОТ уурхайг бүтээн байгуулах нь Монголын төсөв, татварын бодлогод хүчтэй нөлөө үзүүлж, 2009 оны хөрөнгө оруулалт \ХО\–ын гэрээ байгуулахын тулд хуулийн шинэчлэл хийхэд хүргэсэн. Мөн ОТХОГ нь Монголын байгалийн баялгийн бодлогын хүрээнд улс төрийн мэтгэлцээн үүсгэж, баялгийн үндсэрхэг үзлийг тэтгэсэн аж. Газрын гүнд 200 км–ийн хэвтээ туннель байгуулах уурхайн хоёрдугаар шатны ажил нь зардал хэтрүүлсэн, татварын үүргээ биелүүлэгүй, мөн стратегийн чанартай эрдэс баялгийг ордыг үндэстэн дамнасан корпораци хянах явдал нэмэгдсэн зэрэг асуудлын улмаас хойшлогджээ.¹⁴ Хэдий тийм боловч, 2015 онд ОТ гүний уурхайг Хөгжүүлэх болон санхүүжүүлэх Төлөвлөгөөнд гарын үсэг зурж, Дэлхийн Банкны Группын түүхэнд хамгийн том болох Хөрөнгө оруулалтын баталгааны Олон талт Агентлаг \MIGA\–ийнх нь баталгаа, мөн Олон улсын Санхүүгийн корпораци \IFC\–ийнх нь синдикат зээлээр санхүүжүүлэх болсон.¹⁵

Нүүрс, зэс, алтны ашиглагдаагүй ихээхэн баялаг нөөцөөрөө Монгол улс дэлхийн уул уурхайн салбарынхны сонирхлыг татдаг. Иймээс эдийн засаг нь уул уурхайгаас ихээхэн хамааралтай болж, тус салбар ДНБ–ний 20%, экспортын 80%, улсын төвлөрсөн төсвийн орлогын 30%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70%–г эзэлж байна.¹⁶ Байгалийн арвин баялагтай, ДНБ–ний өсөлт 2011 онд 17% хүрсэн (түүнээс хойш 2% дээр очиж тогтсон) үзүүлэлттэй боловч¹⁷, Монгол нь

13 Орбис (Orbis) компанийн тухай мэдэллийн сан, Өмчлөл, Рио ТинтоНээлттэй хувьцаат компани (Orbis corporate database, ownership, Рио Тинто Plc.) Авсан 2017–12–04.

14 Ройтерс, Рио Тинтогийн уурхайн талаарх маргааны бурууг Монгол даах болох нь <http://www.reuters.com/article/mongolia-oyutolgoi-idUSL3N0X01NK20150403>; Өсөлтийн удаашралт, өрийн хэмжээ нь Монголын зээл авах нөхцлийг дордуулж байна https://www.moody's.com/research/Moodys-Mongolias-credit-quality-constrained-by-slowing-growth-and-sizeable--PR_338644. Авсан 2017–08–08.

15 Оюу Толгой нь ОУСК–ийн хамгийн том синдикат зээл, ХОБОТА–ийн хамгийн том баталгааг авч байна, 2016–01 сар <http://www.fn4dev.org/2016/01/19/oyu-tolgoi-ifcs-largest-syndication-deal-and-migas-largest-guarantee>; ЕСБХБ, <http://www.ebrd.com/news/2015/ebd-arranges-us-12-billion-syndicated-loan-for-oyu-tolgoi-mine.html>; http://www.ifc.org/wps/wcm/connect/industry_ext_content/ifc_external_corporate_site/ogm+home/priorities/mining/oyutolgoi2c, <https://www.miga.org/Lists/Press%20Releases/CustomDisp.aspx?ID=506>; мөн Ройтерс <https://www.reuters.com/article/mongolia-ebd-loans/rpt-ebd-says-arranges-1-2-bln-syndicated-loan-for-mongolian-mine-idUSL8N1444RU20151215>. Авсан 2016–12–06.

16 Дэлхийн банк, Орны тойм <http://www.worldbank.org/en/country/mongolia/overview>; мөн <https://www.export.gov/article?id=Mongolia-Mining>. Авсан 2017–04–04.

17 <http://www.gfmag.com/global-data/economic-data/countries-highest-gdp-growth>; <http://www.imf.org/en/Countries/MNG#countrydata>, авсан 2017–12–09. Хатчер П, 2016 (Hatcher, P. 2016.) 'Le boom minier de la Mongolie et la montée du nationalisme des ressources: tensions politiques, promesses électorales et normes néolibérales' Canadian Journal of Development Studies 37(4).

Шигтгээ 1 ОУВС Рио Тинтогийн замыг Монголд засч өгсөн нь

Монгол улс ба түүний нүүдэлчин уламжлалт хүн ам нь эдийн засгийн агуу өөрчлөлтийг саяхан даван туулсан билээ. ЗХУ задарсны улмаас Монгол улс тусгаар тогтнолоо дахин сэргээж, ОУВС, Дэлхийн банк, АХБ-ны санхүүгийн болон бодлогын дэмжлэгээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг зах зээлийн баримжаат эдийн засагт шилжүүлэх бүтцийн өөрчлөлт хийх бодлого хэрэгжүүлсэн аж. Гадаадын төрийн болон хувийн хөрөнгө оруулалт, зах зээл, хувьчлалыг хөхиүлэн дэмжих агуулга бүхий 1990-ээд оноос хэрэглэсэн ‘шок эмчилгээ’ нь байгалийн баялгийг нийтээр ашиглах Монголын түүхэн уламжлалтай зөрчилдөж, ОУВС өөрөө ч хүртэл тодорхойлсноор “шилжилтийн зовиуртай хямрал”-д хүргэжээ. Эдгээр бодлогын өөрчлөлт нь улсаас байгалийн баялгийг удирдах явдлыг алдрагдуулж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг илүүтэй таалсан институциональ бүтцийг бий болгожээ. Төрийн хяналт ийнхүү суларсан нь Монголын баялгийн арвин нөөцийг шохоорхсон гадаадын уул уурхайн компаниудад үүд хаалга нээж, олборлолтыг хялбаршуулсан. SOMO дараагийн нийтлэлдээ ОУВС-аас авсан арга хэмжээнүүд Монголын хууль тогтоох үйл ажиллагаанд Рио Тинтогийн талаас нөлөөлөх боломжийг хэрхэн хангасан бөгөөд энэ нь Монгол улсаас байгалийн нөөцийн талаар хараат бус бодлого явуулахад хэрхэн саад учруулсаныг харуулах болно.

олон улсын зээл тусламж тогтмол хүлээн авч ирсэн,¹⁸ мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай орон юм. Монгол улс энэ оны эхээр (2017) 1990 оноос хойших 6 дахь удаагийн ОУВС-гийн дампуурлаас сэргийлэх зээлд¹⁹ хамрагдсанаар гадаад өр нь мэдрэгдэхүйц нэмэгдэв²⁰. 2017 оны байдлаар Монголын нийт гадаад өр ДНБ 11.2 тэрбум долларыг нугалсантай тэнцэх 26 тэрбумд хүрсэн байна²¹. Хариуд нь цалинг царцаах, хүн амын орлогын татвар нэмэгдүүлэх зэрэг хатуу нөхцөл бүхий төсвийн багц өөрчлөлт хийх үүрэг хүлээжээ.²² Зэс, нүүрс, алт зэрэг уул уурхайн түүхий эдээс хамааралтай байдал нь Монголын эдийн засгийг үнийн

18 1990 оноос хойш хүлээж авсан нийт зээл тусламжийн нэг хүн амд ногдох хэмжээ 100 ам. доллар орчим байж ирсэн, 2016 онд 79 ам. доллар байв. Дэлхийн банк <https://data.worldbank.org/indicator/DI.ODA.ODAT.PC.ZS?end=2015&locations=MN&start=1976&view=chart>, ЭЗХАХБ https://public.tableau.com/views/OECDDACaidatagancebyrecipient_new/Recipients?:embed=y&:display_count=yes&:showTabs=y&:toolbar=no?&:showVizHome=no. Авсан 2017-12-05.

19 <https://www.imf.org/en/News/Articles/2017/05/24/17193-imf-executive-board-approves-financial-arrangement-for-mongolia>, <https://www.bloomberg.com/news/articles/2017-02-19/imf-to-loan-mongolia-440-million-as-part-of-5-5b-bailout>, retrieved 12 June 2017.

20 <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/25697/9781464809941.pdf>, page 108.

21 https://www.mongolbank.mn/eng/liststatistic.aspx?id=4_3; <https://www.ft.com/content/4055d944-78cd-11e6-a0c6-39e2633162d5>; <https://www.focus-economics.com/country-indicator/mongolia/external-debt>; <https://www.gfmag.com/global-data/country-data/mongolia-gdp-country-report>

22 <https://www.bloomberg.com/news/articles/2017-04-19/mongolia-clears-hurdles-needed-for-5-5-billion-imf-led-bailout>

(сүүлийн дөрвөн жилийн хөдөлгөөнтэй адил²³) хэлбэлзэлд эмзэг болгож, улс төрийн хувьд уул уурхайн компаниудын ашиг сонирхолд өртөмтгий болгожээ.

Монгол улсын хувьд Оюу Толгойн уурхайн ач холбогдол, үр нөлөөг санавал Монгол улс, монголчуудад аюулгүй, тогтвортой уул урхайн үйл ажиллагаа болон хөгжлийг хангах тухай Рио Тинтогийн дээрх амлалтыг нарийн чанд шинжих шаардлага байна гэж үзнэ. Оюу Толгойн хөрөнгө оруулалтын онц содон гэрээгээр Рио Тинтод хуулийн ямарваа өөрчлөлтөөс баттай хамгаалагдсан татварын орчин олгогдсон нь уурхайн үйлдвэрлэсэн өртгийн хэдий хэмжээ нь Монголдоо үлдэж, монголын ард түмэн түүнээс хэдий хэмжээгээр хүртэж буй тухай асуултанд хариулт өгөхийг нэхэж байгаа юм.

1.2 Илтгэлийн сэдэв болон шинээр гарах нийтлэлүүд

Эл илтгэл Оюу Толгойн талаарх гурван нийтлэлийн эхнийх нь болох бөгөөд Рио Тинтогоос Оюу Толгойн уурхайг санхүүжүүлэхээр боловсруулж хэрэгжүүлсэн санхүүгийн төлөвлөгөө, Монголын ЗГ-тай хэлэлцэн олж авсан татварын таатай нөхцөлүүд болон үүнээс үүдсэн Монгол, Канадын орлогын алдагдал зэрэг дээр төвлөрч байгаа юм. 2018 оны сүүлээр хэвлэгдэх дараагийн нийтлэл нь Олон улсын санхүүгийн байгууллагууд уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжснээр Монголын төрийн бодлого, хууль тогтоох үйл ажиллагааг тодорхойлоход нөөлөөлж ирсэн тухай өгүүлнэ. Гуравдахь нь Оюу Толгойн санхүүжилтийг хангасан төрийн хэвшлийн институцууд болон тэдгээрийн оролцоо бүхий санхүүгийн тогтолцоо нь Монголын ард түмэн, байгаль орчинд учирч буй сөрөг нөлөөлөл бий болоход хэрхэн үүрэг гүйцэтгэснийг харуулах юм.

Эл илтгэлийг дараах бүтэцтэй боловсруулав. Үүнд: Хоёрдугаар бүлэгт Оюу Толгойн уурхайн үүсгэн байгуулалт, удирдлагын бүтэц зохион байгуулалт болон санхүүжилтийг харуулж, Гуравдугаар бүлэгт Оюу Толгойн уурхай нь Монголын засаг төрийг Ринто Тинтотой эрх тэгш бус барилдлагад оруулсныг тайлбарлахын тулд уг уурхайн Хөрөнгө оруулалтын гэрээний тухай өгүүлсэн болно. Энэ ОТХОГ нь уурхайгаас олсон орлого Монголоос урван зугтах арга сүвэг болж байгаа талаас нэлээд асуудал үүсгэсээр байгаа юм. Дөрөвдүгээр бүлэг нь уурхайг санхүүжүүлэх зээлийг татварын диваанжингуудаар дамжуулах замаар татварын хэмжээг багасгах, татвараас зайлсхийх үйлдэл улмаар Монгол, Канад улсын хувьд бий болж буй орлогын алдагдал зэрэг асуудлыг авч үзэв. Тавдугаар бүлэгт Рио Тинто нь Монгол улсын хууль тогтоомж, хоёр талт татварын хэлэлцээрүүдийг өөртөө таатайгаар хэрэглэхийн тулд Нидерландад шуудангийн хайрцаг төдий бүртгэлтэй компаниудыг ашиглаж ирсэн байдлыг харууллаа.

23 Ээсийн хувьд дэлхийн эрэлтийн 50% бүрдүүлдэг Хятадын эдийн засгаас ихээхэн (гэвч бүрэн бус) хэмжээгээр хамааралтай, <https://www.ft.com/content/0bfdd635-54f6-3b11-9cbf-7b89828070a0>; <https://www.ft.com/content/63e2ed24-02fd-11e7-ace0-1ce02ef0def9>. <http://www.mining.com/copper-best-performing-commodity-2017-analysts/>. Авсан 2017/VIII.

Илтгэлийн сүүлийн бүлэгт судалгааны ажиглалт, гарсан гол дүгнэлтүүд болон Оюу Толгойн уурхай зэрэг байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл дагуулах үлэмж хэмжээний төслийг Монголын ард түмэнд урт удаан хугацааны үр шимтэй болгохын тулд тусгайлан анхаарч шийдвэрлэвэл зохих зарим асуудлыг тусгасан болно.

1.3 Аргачлал

Оюу Толгойн судалгаа нь SOMO-гийн дэлхийн уул уурхай, эрчим хүчний салбарын хөгжлийн харилцан уялдааны талаарх судалгааны төслийн нэг юм. Өмнө нь Монгол улс SOMO-гийн Улс хоорондын хоёр талт татварын гэрээ хэлэлцээр, татварыг багасгах бусад арга замын тухай судалгаанд хамрагдаж байв.²⁴ Энэхүү судалгаанд эрдэм шинжилгээний бүтээл, нийтийн санхүүгийн баримт мэдээлэл, санхүүгийн болон уул уурхайн Вэб мэдээлэл, Ройтерсын Айкон (Reuters Eikon) болон Орбис (Orbis) гэх компанийн тухай мэдээллийн сангууд, санхүүгийн тайлан, жилийн тайлан баланс, мөн Оюу Толгойн үйл ажиллагаанд хяналт тавьж буй Оюу Толгойн Хяналт ТББ, ОпенОйл (OpenOil), банкны үйл ажиллагааны хяналтын сүлжээ Иргэд Европын Төлөө (Citizens for Europe) зэрэг ТББ-ын мэдээлэл болох өргөн хүрээний төрөлжсөн эх сурвалжуудыг ашиглав. Харамсалтай нь Эрдэнэс Оюу Толгой болон Оюу Толгой ХХК-ийн жилийн тайлан баланс SOMO-д хүртээмжгүй байв. Энэхүү илтгэлийн өмнөх хувилбарт тусгасан ОТ-ийн санхүүжилтийн арга схемийг хөндлөнгийн шинжээчээр хянуулсан болно.²⁵


SOMO нь чанар баталгаажуулах дотоод журмынхаа дагуу аливаа судалгаа, илтгэлийг гагцхүү өгүүлэгдэж буй компани танилцаж саналаа өгсөний дараа нийтэлдэг эсвэл гуравдах талтай хуваалцдаг дадалтай юм. Уг илтгэлийг 2017 оны 12 дугаар сарын 23-нд Рио Тинто болон Түркойз Хилл Ресурс компанид санал авах зорилгоор хүргүүлсэн бөгөөд тэдгээрээс илгээсэн саналыг илтгэлдээ зохих хэмжээнд тусгаж, бүрэн эхийг нь SOMO-ийн вэб хуудсан дээр байршуулсан болно.

24 <https://www.somo.nl/should-the-netherlands-sign-tax-treaties-with-developing-countries/>. Авсан 2017-04-04.

25 Уг шинжээч санхүүгийн зөвлөхийн ажил эрхэлдэг тул нэрийг нь заахгүй байхыг хүссэн болно.

2 Оюу толгойн уурхай

Зураг 1. Өмнийн говийн бүс дэх Оюу Толгойн уурхай²⁶



2.1 Оюу Толгойн хайгуул ба уурхайн хөгжил

Оюу Толгойн уурхай нь Монголын нийслэл Улаанбаатраас урагш 555 км-ын зайнд Говийн нутагт байршилтай. Энэхүү ерөнхийдөө хуурай газар нь нүүдэлчин малчдын амьдрах орчин, олон төрөл зүйлийн ховордсон амьтан, ургамлын нутаг болно²⁷. Анх 2001 онд алт, зэсийн томоохон ордыг илрүүлснээс хойш арван хэдэн жилийн туршид хайгуул хийгдэж ирэв²⁸. Оюу Толгой ил уурхайн барилгын ажил 2011 онд эхлэв.²⁹ 2013 онд урхайн анхны баяжмалыг экспортод гаргав. 2016 оны байдлаар нийт 202,200 тонн зэс, 18512 кг алт үйлдвэрлэв.³⁰ Мөн Өмнөт Оюу Толгой нэртэй 2013 онд ашиглалтад орсон энэхүү ил уурхай нь Оюу Толгой төслийн эхний ээлж бөгөөд Хьюго Норд

26 http://www.turquoisehill.com/s/oyu_tolgoi.asp?ReportID=379189

27 <https://www.conservationgateway.org/ConservationByGeography/AsiaPacific/mongolia/Documents/Annex%20D.%20Connectivity%20Report%20ENG.pdf>

28 <http://www.riotinto.com/copperanddiamonds/oyu-tolgoi-4025.aspx>

29 <http://www.mining.com/ivanhoe-mines-construction-of-oyu-tolgoi-copper-gold-silver-complex-advancing-toward-planned-start-of-commercial-production-in-the-first-half-of-2013/>

30 http://www.turquoisehill.com/i/pdf/news/2016-03-17_NR.pdf; <https://www.bloomberg.com/research/stocks/private/snapshot.asp?privcapId=100472211>

нэртэй одоо баригдаж буй далд уурхай нь төслийн хоёрдахь шат болох юм.³¹ Барилга угсралтын ажил нь таваас долоон жил болох төлөвтэй.³² Төслийн 1, 2 шатны үйл ажиллагааны хэмжээ, цар хүрээг авч үзвээс нийгэм, байгаль орчны одоогийн ба болзошгүй эрсдэл, нөлөөлөл ихээхэн санаа зовоох асуудал мөн болоод байгаа юм.

2.2 Оюу Толгойн нийгэм, байгаль орчны нөлөөлөл

Эхний шатанд ил уурхай бүтээн байгуулах үед орон нутгийн хөгжил, байгаль орчны нөлөөллийн асуудлаар нутгийн хүн амтай хэдий хэмжээнд зөвлөлдөж, ямар мэдээлэл өгч байсан тухайд асуудал үүсч байсан. Ган зудад өртөмтгий энэ эмзэг бүсэд амьдардаг нүүдэлч малчид нь хувийн өмч болон том хэмжээний үйлдвэрлэл гэхээс илүү байгалийн нөөцийн нийтийн удирдлагын уламжлалтай юм. Тухайлбал, ундны усны хүртээмж, чанар, бэлчээрийн хүртээмж, Ундай голын гольдролын өөрчлөлт, уурхайн дэд бүтцийн байгуулалтаар хохирсон талуудад зоргоор нөхөн олговор тогтоох, эмнэлгүүдийн нэмэгдэх ачаалал, нутгийнхны нүүлгэн шилжүүлэлт зэрэг асуудлууд шийдлээ олоогүй байв³³. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ \БОНБНҮ\ нь зөвхөн 1 дэх шатанд хамааралтай бөгөөд уурхайн барилгын ажил эхэлсний дараа танилцуулагдсан³⁴, үндэслэл муутай, дутуу дулимаг тооцоотой хийгдсэн аж³⁵. Эрсдлүүдийг бүрэн тооцоогүй, нутгийн оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдралын баталгааг харгалзаагүй, Говь нутгийн усны нөөц болон биологийн төрөл зүйл³⁶-ийг хамгаалах бодлого, арга хэмжээг тодорхойлж чадаагүй, уурхай болон дэд бүтцийн нөлөөг цогцоор нь тусгаж дүгнээгүй³⁷ нь үнэлгээг дутуу дулимаг буюу бүр итгэлгүй болгоход хүргэж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөр ган зуд тохиох болон малчдын бэлчээрийн хомсдлоор нүүдэллэх боломж хумхигдсантай хавсарсан орон нутгийн засаглалын сул дорой байдал нь малчдын

31 http://www.turquoisehill.com/i/pdf/ppt/TRQ_Macquarie_Conference_Presentation_9_June_2016.pdf

32 http://ot.mn/media/ot/content/operations/underground/OT_Underground_Mine_Poster_EN.pdf

33 IFC Compliance Advisor Ombudsman, CAO Assessment Report: Second Complaint (Oyu Tolgoi-02) (IFC #29007 and MIGA #7041), Jul 2013, http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/OT-2_Assessment_Report_ENG.pdf, retrieved 10 Sep 2017; Urgewald, Bank Information Center, OT Watch, and CEE Bankwatch, Spirited away – Mongolia's mining boom and the people that development left behind, Dec 2011, <http://bankwatch.org/sites/default/files/spirited-away-mongolia-mining.pdf>, retrieved 10 Sep 2017. EBRD, Oyu Tolgoi, 5 Sep 2012, <http://www.ebrd.com/work-with-us/projects/psd/oyu-tolgoi-.html>, retrieved 5 Sep 2017; Mining.com, US raises serious concerns over Oyu Tolgoi's environmental, social impact, 9 Mar 2013, <http://www.mining.com/us-raises-serious-concerns-over-oyu-tolgois-environmental-social-impact-21812>, retrieved 8 Aug 2017; The Guardian, Rio Tinto accused of environmental and human rights breaches, 18 Apr 2013, <https://www.theguardian.com/business/2013/apr/18/rio-tinto-environmental-human-rights-breaches>, retrieved 16 Dec 2017

34 Oyu Tolgoi Watch, Letter, 20 Apr 2012, <http://en.minewatch.mn/wp-content/uploads/2011/12/Oyu-Tolgoi-Watch-Letter-to-UKFCO-draft1.doc> (18 Jul 2014).

35 <https://bankwatch.org/publication/a-useless-sham-review-of-the-oyu-tolgoi-copper-and-gold-mine-environmental-and-social-impact-assessment>; <http://www.mining.com/us-raises-serious-concerns-over-oyu-tolgois-environmental-social-impact-21812/>

36 European Bank for Reconstruction and Development, Project Number 41158, 5 Sep 2014, <http://www.ebrd.com/pages/project/psd/2012/41158.shtml> (18 Jul 2014).

37 OT Watch, "Comments on the Oyu Tolgoi Environmental and Social Impact Assessment", 16 October 2012, http://ot.mn/sites/default/files/documents/Feedback_ESIA_OT_Watch_letter.pdf (18 Jul 2014).

амьжиргааг эмзэг болгоод зогсохгүй³⁸ тэдний шууд хараат амьдрах орчныг нь тогтворгүй болгожээ.³⁹

2012 онд малчид Оюу Толгойн Хяналт болон Говийн газар шороо ТББ-дын тусламжтайгаар Олон улсын санхүүгийн корпорац (IFC)-ийн Нийцэл, Зөвлөлгөө ба Эрхийг хамгаалагчийн газарт хоёр гомдол гаргажээ.⁴⁰

Нэг нь уурхайн газрын болон усны хэрэглээ нь малчдын ахуй амьдрал⁴¹ нөлөөлөх тухай, нөгөөдөх нь Ундай голын гольдролыг өөрчлөхийг эсэргүүцсэн гомдол.⁴² Талууд Оюу Толгойн Хяналт болон Хариуцлагын Зөвлөх (Accountability Counsel) ТББ-ын оролцоотойгоор 2013 оны гуравдугаар сараас 2017 оны тавдугаар сар хүртэл хугацаанд маргаан шийдвэрлэх хэлцэлд орж одоогоор бэлчээрийн (10), усны (7), хяналтын (10), нөхөн төлбөрийн (28), Ундай гол болон газрын төрх байдлын хамгаалалттай холбогдолтой (30) асуудлаар мөн Тогтвортой амьжиргааны Хөтөлбөрийн дотор 10 төсөл хэрэгжүүлэх, 8 нэр заасан газар нөхөн сэргээх ажиллагаа явуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэд хэдэн багц тохиролцоонд хүрээд байна⁴³.

Оюу Толгойн далд уурхайн хөгжил, Санхүүжилтийн төлөвлөгөө (OTUMDFP 2015)-ний дагуу Оюу Толгойн үйлдвэрлэлийн 80 хувийг бүрдүүлэх хоёрдугаар шатны барилга ба олборлолт газар доор явагдах юм. Энэ ээлж нь 2019 онд ашиглалтад ороод ил ба далд уурхайн үйлдвэрлэл жилдээ 500,000 тоннд хүрэх аж.⁴⁴ Газар дорхи хүдрийг гаргахад 1300м гүнд байгуулсан 200 км урт хэвтээ туннель болон 10 км урт конвейер тууз ашигласан блокчлон олборлолтын аргыг хэрэглэж байгаа юм. Ажиллагааны цар хүрээ болон блокчлон олборлох аргыг хэрэглэх нь суулт, нуралт өгөх аюултай, мөн олборлолт хийсэн хэсгийн гадаргуу нь байнгын тогтворгүй болж үлдэх магадлалтай. Блокчлон олборлох энэ аргын үр дагавар одоо хүртэл сайтар ойлгогдоогүй байгаа учраас одоогоос илүү нарийвчилсан тооцоо хийх шаардлагатай гэж үздэг

38 Mung, Brown and Agrawal, 2013, *Global Environmental Change* 23:1673–1683; Jackson, 2015, *Geoforum* 66:94–105.

39 Upton (2010) *Geoforum* 41: 865–874; Sternberg and Paillou (2015) *Journal of Arid Environments* 118:21–27, WB, *Groundwater Assessment of the Southern Gobi Region*, April 2010, <http://documents.worldbank.org/curated/en/734471468323712803/pdf/627890REPLACEMENT07018020110Box361493B.pdf>, retrieved 18 Jul 2014. Multi Disciplinary Team and Independent Expert Panel Summary Report, Jan 2017, http://www.caoombudsman.org/cases/document-links/documents/MDTIEP_FINALREPORT_ENG_January292017_000.pdf, retrieved 02 Jan 2018.

40 Mongolian herders file complaint with IFC & Multilateral Insurance Guarantee Agency's accountability mechanism over Rio Tinto mine being considered for financial support, no date, <https://www.business-humanrights.org/en/mongolian-herders-file-complaint-with-ifc-multilateral-insurance-guarantee-agency%E2%80%99s-accountability-mechanism-over-rio-tinto-mine-being-considered-for-financial-support>, retrieved 8 August 2017. See also the complete CAO case documents at http://www.cao-ombudsman.org/cases/case_detail.aspx?id=191.

41 IFC Compliance Advisor Ombudsman, Complaint Regarding the Oyu Tolgoi Project (IFC #29007 and MIGA #7041), April 2013, <https://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/08/4.13-CAO-Assessment-Report.pdf>, or specifically for Phase 1 at http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/OyuTolgoiCAOComplaint_Oct122012_Redacted.pdf retrieved 8 Aug 2017.

42 IFC Compliance Advisor Ombudsman, Complaint Regarding the Oyu Tolgoi Project (IFC #29007 and MIGA #7041), April 2013, <https://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/08/7.13-CAO-Assessment-Report.pdf>, or specifically for Phase 2 at http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/UndaiRiverComplaint_Feb32013_ENG.pdf retrieved 8 Aug 2017.

43 Herders' complaint resolution agreement #1 and #2. <https://www.accountabilitycounsel.org/blog-post/mongolian-herders-secure-historic-agreement-with-oyu-tolgoi-mine-government-to-protect-herds-health-and-livelihoods/>

44 <http://www.turquoisehill.com/i/pdf/ppt/Presentation-Dec-06-2017.pdf>, retrieved 2 Jan 2018.

байна⁴⁵. Рио Тинто нь сул хөрсийг орхиж ашигт ажиллагааг дээшлүүлэх зорилгоор туннель дагуу агуйн хянагч (cave tracker) төхөөрөмж ашиглаж, чингэснээр агуйн олборлолтыг аюулгүй болгоно гэж найддаг аж.⁴⁶ Гэвч туршлагаас харахад газар хөрсний суулт, нуралтаас үүдэн “газрын гадаргуунд орох өөрчлөлт ихээхэн байх ба байгаль орчны томоохон сүйрэлд хүргэх аюултай”⁴⁷. ОТ-н далд уурхайн хөгжил, санхүүжилтийн төлөвлөгөө \OTUMDFP 2015\ болон ОТ-н Техникийн илтгэл \OTTR 2014\ -ийг хоёрдахь үе шат-гүний уурхайн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тодотгол эсвэл шинэ дүгнэлт маягаар ч оруулаагүйг шүүмжилдэг.⁴⁸ Улмаар, 2012 оны БОННУ-ний тоон шинжилгээгээр дээрх уршиг ихээхэн хэмжээтэй байх ба суултын бүс хамгийн багадаа 8 км кв талбайг хамрах нь аюулгүй байдалд эрсдэл учруулахаар тогтохгүй, гидрогеологи болон геологийн нөхцөлд сөргөөр нөлөөлөхүйц байгаа юм.⁴⁹

2.3 Оюу Толгойн компанийн өмчлөлийн бүтэц

Оюу Толгойн нөөц нь Канадын уул уурхайн Айвэнхоу Майнз (Ivanhoe Mines) компанийн эзэмшилд байж Рио Тинто 2012 онд уг компанийн дийлэнх хувийн хувьцааг худалдаж авсан юм.⁵⁰ Дараа нь Айвэнхоу Майнз нэрээ Оюу Толгой мөнгөл нэрийн англи орчуулга Түркойд Хилл Ресурс⁵¹ болгон өөрчилж, Рио Тинтогийн өмчлөл 51% болсныг зарласан юм.⁵² Түркойд Хилл Ресурс компани нь Канадад бүртгэлтэй боловч Рио Тинтогийн өмчлөлийн бүс 49% хувьцаа нь Нью Йоркийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байна.

Оюу Толгойн уурхайн 1, 2 дугаар шатны ил ба далд уурхай нь Монголд бүртгэлтэй Оюу Толгой ХХК хэмээх компанийн өмчлөлд байна. Оюу Толгой ХХК уурхайн 66%, үлдэх 34%-ийг төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой компани өмчилдөг болно.⁵³ Энэхүү төрийн өмчлөл нь Монголын 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу төр нь өөрийн нутаг дэвсгэр дэх уул уурхайн

-
- 45 Woo, K-S et al (2013) Empirical investigation and characterization of surface subsidence related to block cave mining, *International Journal of Rock Mechanics & Mining Sciences* (61)13: 31-42; Vyazmensky, A. (2008) Numerical modelling of surface subsidence associated with block cave mining using a finite element/discrete element approach. Thesis submitted in partial fulfillment of the requirements for the degree of doctor of philosophy in the earth sciences, Simon Fraser University.
- 46 http://www.riotinto.com/ourcommitment/spotlight-18130_18228.aspx
- 47 http://www.redpathmining.com/wp-content/uploads/2012/07/Block-Caving_Mining-Magazine-June-2012.pdf
- 48 <https://bankwatch.org/publication/oyu-tolgoi-phase-2-plans-issues-and-risks>
- 49 ESIA Oyu Tolgoi Project ,2012, Section C Impact Assesment, Chapter 4, Topography, Landscape, Geology and Topsoils, pg 10 at http://ot.mn/media/ot/content/page_content/commitments/ESIA/1_ESIA/Impact_Assessment/ESIA_OT_C4_Topography_EN.pdf, retrieved 02 January 2018.
- 50 Financial Post, Rio Tinto takes majority stake in Ivanhoe, 24 January 2012, <http://business.financialpost.com/investing/rio-tinto-takes-majority-stake-in-ivanhoe>, Авсан 2017-08-08; Financial Times, Ivanhoe chief departs as Rio tightens grip, 18 April 2012, <https://www.ft.com/content/970e22c6-8973-11e1-85b6-00144feab49a>. Авсан 2017-08-08. <http://business.financialpost.com/investing/rio-tinto-takes-majority-stake-in-ivanhoe>.
- 51 Market Wired, Ivanhoe Mines Changes Name to Turquoise Hill Resources, 2 August 2012, <http://www.marketwired.com/press-release/ivanhoe-mines-changes-name-to-turquoise-hill-resources-tsx-ivn-1686881.htm>. Авсан 2017-08-08.
- 52 Reuters Eikon database, Turquoise Hill Resources, Shareholders report. Авсан 2017-12-06. Түркойд Хилл Ресурс-ын хувь нийлүүлэгчдийн тайлан.
- 53 Оюу Толгой website, Оюу Толгой Shareholders, no date, <http://ot.mn/oyu-tolgoi-shareholders/>. ОТ вэб хуудас, ОТ хувь нийлүүлэгчид, огноогүй. Авсан 2017-12-06.

компанийн 50 хүртэлх хувийг өмчилж болох тухай заалтаас үүдэлтэй юм.⁵⁴ Оюу Толгой ХХК-ийн захирах дээд компани нь Түркойз Хилл Ресурс бөгөөд түүний дийлэнх хувьцаа нь Рио Тинтогийн мэдэлд байдаг. Рио Тинто ОТ уурхайн ажлуулагч компани мөн болох нь тус компани уурхайг өмчлөдөгөөс гадна шууд захиран удирддаг гэсэн үг юм.

Оюу Толгой ХХК буюу өөрөөр хэлвэл түүний олонх хувьцааны эзэн Рио Тинто нь ОТ-н уурхайгаас гадна ойр орчимд байршилтай хэд хэдэн өөр орд газарт лицензи эзэмшдэг байна. Оюу Толгой ХХК болон Канадын алт олборлогч Entrée Resources компанийн байгуулсан хамтарсан компаниар дамжуулан Шивээ толгойн ордын⁵⁵ зүүн хэсэг, мөн Жавхлантын ордын⁵⁶ ашиглалтын лицензийн хувь эзэмшигч юм байна. Энэхүү Антре/Оюу Толгой ЖейВи Проперти (Entrée/Оюу Tolgoi JV Property) нэртэй хамтарсан үйлдвэрийн 80%-ийг Оюу Толгой ХХК, үлдэх 20%-ийг Антре Ресурс өмчилдэг төдийгүй Рио Тинто болон Түркойз Хилл Ресурс компаниуд аг Антре Ресурс компанийн өөрийнх нь хувьцааны 10% ба 8%-ийг тус тус өмчилдөг байна.⁵⁷

ОТ уурхайгаас ашиг олох Түркойз Хилл Ресурс компанийн Рио Тинтогоос бусад хувь нийлүүлэгч нь дараах компаниуд болно. Үүнд: SailingStone Capital Partners (\$754 сая долларын хувьцаа), Pentwater Capital Management (\$298 сая), Temasek Holdings (\$227 сая), Capital Growth Management (\$118 сая), Vanguard Group (\$74 сая), болон Anchor Bolt Capital (\$68 сая).⁵⁸ Temasek Holdings гэх Сингапурын төрийн баялгийн санг захирдаг компаниас бусад нь хөрөнгө оруулалтын менежер \ зуучлалын\ компаниуд юм.⁵⁹

Мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдын дунд арван тэтгэврийн сан байдаг байна. Тэдгээрийн зарим томоохныг дурдвал: CPP Investment Board (24.9 сая ам.долларын хувьцаа), PSP Investments (16.9 сая), British Columbia Investment Management Corp. (16 сая), Florida State Board of Administration (10 сая).⁶⁰ Нидерландын хоёр том тэтгэврийн сан – PGGM ба APG – нь 1.8 сая ам.доллар болон 598 мянган ам. долларын хувьцааг Түркойз Хилл Ресурс компанид тус тус эзэмшдэг байна.⁶¹ Түркойз Хилл Ресурс нь Оюу Толгойгоос гадна өөр олон уурхайн компанийг өмчилдөг бөгөөд түүний өмчлөлийн бүтэц, охин компанийн сүлжээ маш өргөн билээ. Дорх зурган дээр эл судалгааны хүрээнд олж тогтоосон Оюу Толгойн уурхайтай холбогдол бүхий охин компаниудыг харуулав.

54 US Department of State, 2013 Investment Climate Statement – Mongolia, April 2013, <https://www.state.gov/e/eb/rls/othr/ics/2013/204697.htm>. Авсан 2017-08-08.

55 Ордын баруун хэсэг нь тэр чигээрээ Антре Ресурс (Entrée Resources)-ын өмчлөлд. Антре Ресурс, ОТ-ийн газрын зураг, 2018 оны 1-р сар. http://www.entreeresourcesltd.com/_resources/projects/overview/lookout-hill-july2017-web.jpg, Авсан 2017-8-08.

56 Антре Ресурс-ын вэб хуудас, Тойм, огноогүй, <http://www.entreeresourcesltd.com/projects/entree-oyu-tolgoi-joint-venture/overview/>.

57 Антре Ресурс-ын вэб хуудас, Бидний тухай, огноогүй, <http://www.entreeresourcesltd.com/>. Авсан 2017-08-08.


58 Ройтерс Айкон (Reuters Eikon), Түркойз Хилл Ресурс-ын хувь нийлүүлэгчдийн тайлан. Авсан 2017-08-08.

59 Bloomberg, Company Overview of Temasek Holdings (Private) Limited, no date, <https://www.bloomberg.com/research/stocks/private/snapshot.asp?privcapId=107637>. Авсан 2017-08-08.

60 Ройтерс Айкон, Түркойз Хилл Ресурс-ын хувь нийлүүлэгчдийн тайлан. Авсан 2017-08-08.


61 Ройтерс Айкон, Түркойз Хилл Ресурс-ын хувь нийлүүлэгчдийн тайлан. Авсан 2017-08-08.

Зураг 2 Оюу Толгой ХХК ба Антре Ресурсийн тус тусдаа болон хамтарч эзэмшдэг лицензийн зураглал⁶²



62 http://www.entreeresourcesltd.com/_resources/projects/overview/Lookout-Hill-July2017_WEB.jpg

Зураг 3 Оюу Толгойн өмчлөлийн бүдүүвч⁶³



Зургийн баруун талд ОТ уурхайн зуун хувь эзэмшигч Оюу Толгой ХХК-ийн Монголын ЗГ-ын 34%-ийн хувийг хэрхэн хоёр компаниар дамжуулан өмчилж байгааг харуулж байна. Зүүн гар талд, Түркойз Хилл Ресурс буюу Рио Тинто нь Оюу Толгой ХХК-ийг удирдахдаа олон охин компанийн хоёрын хоёр гинжин сүлжээг ашиглаж байгааг харуулна: гол сүлжээ нь Нидерланд дахь хоёр компани, нөгөөдөх нь Түркойз Хилл Ресурс-ын Канад дахь охин компани. Зүүн хэсгийн эцэст Оюу Толгой ХХК-ийн 0.21%-ийн хувьцааг эзэмшдэг Британийн Виргинийн арлуудад бүртгэлтэй THR Оуу Tolgoi гэх компанийг харуулсан бөгөөд энэ компанийн эзэн нь Түркойз Хилл Ресурс-той холбогдох Делавер муж улсад бүртгэлтэй компанийн Аруба дахь охин компани юм. Британийн Виргинийн арлууд, Аруба, Делаверын аль аль нь хөнгөлөлттэй татварын \диваажин\ нутагт тооцоогддог.⁶⁴ THR Оуу Tolgoi компанийн ОТ уурхай дахь оролцоог тодорхойлоход хүндрэлтэй боловч уул уурхайг төдийлөн эрхлэдэггүй, харин татвараас

63 Орбис (Orbis) мэдээллийн сан, Рио Тинто нээлттэй хувьцаат компани, Өчлөлийн тайлан (Rio Tinto Plc, Ownership report). Авсан 2017-12-04; ОТ, Манай компани (Оуу Tolgoi, Our Company), <http://ot.mn/our-company/en/?eoi>, огноогүй. Авсан 2017-12-04

64 Санхүүгийн нууцлалын индекс 2015 (Financial Secrecy Index 2015, 2015), <http://www.financialsecrecyindex.com/>. Авсан 2017-08-08

зайлсхийх үйл ажиллагаатай холбогддог Британийн Виргинийн арлуудад бүртгэлтэй нь гагцхүү санхүүгийн зорилгоор байгуулагдсаныг нь харуулна. Түркоиз Хилл Ресурс болон Рио Тинтогоос уг илтгэлийн талаар өгсөн саналд THR Оюу Tolgoi компани нь 2009 оноос өмнөх үеийн санхүүгийн бүтцийн үлдэгдэл ба түүнээс хойш уг компанийг Монгол дахь үйлажиллагааг санхүүжүүлэх зорилгоор ашиглаагүй гэсэн бий. Гэвч энэхүү компанийг татвараас зайлсхийх үйл ажиллагааг дэмжихээс өөр аливаа юмаар тодроогүй Британийн Виргинийн арлуудад бүртгүүлсэн нь түүний үүсэл угтаа санхүүгийн сэдэлтэй байсан гэж үзэх үндэслэл юм. Британийн Виргиний арлуудад ил тод байдал дутмаг байдгийн улмаас компанийн өнөөгийн чиг үүрэг бүрхэг байна. Энэ асуудал болон ОТ уурхайтай холбогдон яригдах татвараас зайлсхийх явдалд Нидерландын хоёр охин компанийн гүйцэтгэх үүрэг ролийг эл илтгэлийн 4 дүгээр бүлэгт наривчлан өгүүлнэ.

2.4 Санхүүжилт

Өмнө хэлсэнчлэн Түркоиз Хилл Ресурс нь Оюу Толгой ХХК-ийн 66% -ийг, үлдэх 34% -ийг Эрдэнэс Оюу Толгой ТӨК эзэмшдэг. Оюу Толгойн ил уурхай, түүнтэй холбогдолтой дэд бүтэц, Хьюго Норд далд уурхайн 1 дэх болон 2 дахь шатны хөрөнгө оруулалтын нийлбэр өртөг нь 12 тэр бум ам, доллар болох төсөвтэй юм.⁶⁵

ОТ уурхайн эхний ээлжийг барьж байгуулахад болон үйл ажиллагааг явуулахад өмчлөгчид нь 6.6⁶⁶ тэрбумаас 7.8⁶⁷ тэрбум ам.доллар хүртэл хөрөнгө босгох тооцоо байсан. Эрдэнэс Оюу Толгой ТӨК өөрийн эзэмшлийн 34% -ийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэргүй байсан тул Түркоиз Хилл Ресурс буюу тэр үед Айвэнхоу Майнз компаниас зээлдэхэд хүрчээ. Тэрхүү зээллэгийн хүүг тухайн үеийн Лондон дахь банк хоорондын санал болгох хүү (LIBOR) дээр нэмэх 6.5% -иар тогтоосон.⁶⁸ Эрдэнэс Оюу Толгой ТӨК нь авсан зээлээ Түркоиз Хилл Ресурс-д эргэн төлөх боломжгүй байх магадлалыг харгалзан мөн Түркоиз Хилл Ресурс-ын алдагдалгүй байдлыг хангах зорилгоор Оюу Толгой ХХК-иас Эрдэнэс Оюу Толгой ТӨК-д төлөх аливаа ногдол ашгийн төлбөр эл зээлийг бүрэн төлж дуусталх хугацаанд Түркоиз Хилл Ресурс компанид төлөгдөнө

65 Олон улсын санхүүгийн корпораци (OYCK / IFC), Төсөл № 29007, 2013-02-28 (International Finance Corporation, Project number 29007), 2013-02-28, <http://ifcext.ifc.org/ifcext/spiwebsite1.nsf/ProjectDisplay/SII29007>. Авсан 2014-07-18.

66 Oyu Tolgoi LLC, "Official statement of Oyu Tolgoi LLC in relation to information, data and facts related to Oyu Tolgoi discussed during open session of the State Great Khural dated 1 February, 2013," 5 February 2013, <http://www.mongolia-economy.com/official-statement-of-oyu-tolgoi-llc-in-relation-to-information-data-and-facts-related-to-oyu-tolgoi-discussed-during-open-session-of-the-state-great-khural-dated-1-february-2013/>. Авсан 2016-12-12.

67 Market Wired, Turquoise Hill Announces Financial Results and Review of Operations for 2014, 24 March 2015, <http://www.marketwired.com/press-release/turquoise-hill-announces-financial-results-and-review-of-operations-for-2014-nyse-trq-2003339.htm>. Авсан 2015-07-14.

68 Erdenes Mongolia LLC, Ivanhoe Oyu Tolgoi (BVI) Ltd, Oyu Tolgoi Netherlands BV, and Oyu Tolgoi LLC, Amended and Restated Shareholders Agreement, article 11.3e, 8 June 2011, <http://www.turquoisehill.com/i/pdf/OT-ARSHA-ENG-2011-0608-Executed.pdf>. Авсан 2017-09-08; Oyu Tolgoi Netherlands BV, annual reports for 2013, 2014, and 2015. тайлангуудыг Нидерландын Худалдааны танхимын вэб хуудаснаас татаж болно: <https://www.kvk.nl/zoeken/> (вэб хуудас голланд хэлээр).

гэж Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасан байдаг.⁶⁹ Төслийг санхүүжүүлэхэд хэрэглэсэн зээлийн аугаа хэмжээ болон зээлийн хүүг бодолцовоос МУ-ын ЗГ-т ногдох ашгийн хэмжээ маш бага байх магадлалтай. OpenOil иргэний нийгмийн байгууллагаас 2015 онд гаргасан судалгаанд Монголын төр Оюу Толгойн уурхай дахь өөрийн хувьцаанд ногдох ашгаа автал олон жил өнгөрөх тухай тэмдэглэжээ.⁷⁰ 2017 оны 6 сарын 1-ний байдлаар буюу ОТ уурхай ашиглалтанд орсноос дөрвөн жилийн дараа зээлийн үлдэгдлийн тайлан тэнцлийг харахад МУ-ын ЗГ-аас Түркойз Хилл Ресурс-д төлөх өрийн хэмжээ 1.1 тэрбум ам.доллар байсаар байжээ.⁷¹ Монголын төр болон Оюу Толгойн бусад хувьцаа эзэмшигчийн хэн нэгэн ногдол ашгаа одоо хүртэл аваагүй явж байхад Рио Тинто нь Оюу Толгойд өгсөн зээлээрээ ашиг олсоор байна. Энэ ашиг орлогын тухай цаашид өгүүлэх болно.

Уул уурхайн салбар нь татвар төлөхөөс зугтах нарийн арга мэх хэрэглэдгээрээ нэрд гарсан аж.⁷² Уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа явуулж буй улсад төлвөл зохих татвараа бууруулахын тулд менежментийн төлбөр болон эрдэс борлуулалтын үнийг шилжүүлэх,⁷³ валют хоорондын банкны хүүний своп⁷⁴ зэрэг иж бүрдэл аргыг ашигладаг. Эдгээр арга нь үйл ажиллагааны -- жишээ нь Оюу Толгой ХХК-ийн -- түвшинд зардлаа хөөрүүлж орлогоо бууруулах, харин татвар багатай улсад орлогоо нэмэгдүүлэхэд чиглэдэг юм. Өнөөгийн байдлаар Рио Тинто татвар багатай Сингапур луу үнэ шилжүүлж Австралийн татвараас зайлсхийсэн гэх үндэслэлээр Австралийн засгийн газраас гаргасан 360 сая ам.долларын нэхэмжлэлийг заргалдаж байгаа аж.⁷⁵ Оюу Толгой ХХК жилийн тайлан тэнцлээ нийтлэх үүрэг хүлээдэггүй учраас компанийн санхүүгийн баримт бичигтэй танилцаж ийм арга хэрэглэж буй эсэхийг нь тогтоох бололцоогүй юм.

-
- 69 Оюу Толгойн хувь нийлүүлэгчдийн шинэчлэгдсэн Гэрээ, 2011, 15.2.b зүйл анги, Erdenes Mongolia LLC, Ivanhoe Oyu Tolgoi (BVI) Ltd, Oyu Tolgoi Netherlands BV, and Oyu Tolgoi LLC, Amended and Restated Shareholders Agreement, article 15.2b, 8 June 2011, <http://www.turquoisehill.com/i/pdf/OT-ARSHA-ENG-2011-0608-Executed.pdf>. Авсан 2017-09-08.
- 70 Оюу Толгойн санхүүжилтийн загвар, Open Oil, Oyu Tolgoi Financial Model: Narrative Report, Sep 2016, <http://openoil.net/wp/wp-content/uploads/2016/10/Oyu-Tolgoi-Project-Fiscal-Model-Narrative-Report.pdf>. Авсан 2017-11-20.
- 71 Turquoise Hill Resources, Oyu Tolgoi: Advancing value, creating options, August 2017, <http://www.turquoisehill.com/i/pdf/ppt/Presentation-Aug-2017-FINAL.pdf>. Авсан 2018-01-02
- 72 Natural Resource Governance Institute, Preventing Tax Base Erosion in Africa: a Regional Study of Transfer Pricing Challenges in the Mining Sector, July 2016, https://resourcegovernance.org/sites/default/files/documents/nrgi_transfer-pricing-study.pdf, Авсан 2018-01-02. https://resourcegovernance.org/sites/default/files/documents/nrgi_transfer-pricing-study.pdf. Авсан 2018-01-02.
- 73 Publish What You Pay, Many ways to lose a billion, June 2017, <http://www.publishwhatyoupay.org/wp-content/uploads/2017/07/PWYP-Report-ManyWaysToLoseABillion-EN-INTERACTIVE.pdf>. Авсан 2018-01-02.
- 74 ABC News, The tax trick big miners use to avoid paying millions, 6 November 2017, <http://www.abc.net.au/news/201711-06/ato-investigating-multinationals-amid-paradise-papers-leak/9075642>, retrieved 2 January 2018; Australian Taxation Office, Arrangements involving related party foreign currency denominated finance with related party cross currency interest rate swaps, 26 April 2016, http://law.ato.gov.au/atolaw/view.htm?docid=%22TPA%2FTA20163%2FNAT%2FAT_0%2F00001%22. Авсан 2018-01-02.
- 75 Financial Times, Rio Tinto to fight \$360m Australian tax bill, 5 April 2017, <https://www.ft.com/content/676d74c0-1a11-11e7bcac-6d03d067f81f>. Авсан 2017-12-10.

3 Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ

2009 оны 10 дугаар сард таван жил үргэлжилсэн яриа хэлэлцээний дүнд Оюу Толгойн хөрөнгө оруулалтын Гэрээ \ОТХОГ\–нд Айвэнхоу Майнз, Рио Тинто болон МУ–ын ЗГ гарын үсэг зурсан аж. Энэхүү Гэрээгээр Түркойз Хилл Ресурс компанийн Оюу Толгойд оруулах хөрөнгө оруулалтын нөхцөл, баталгааг тогтоож, дэд бүтцэд хөрөнгө оруулах, байгаль орчныг хамгаалах шаардлага хангах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, оруулсан хөрөнгийг нийгэмчлэхээс хамгаалах, мөн хөрөнгө оруулалттай холбоотой татварын орчныг тогтоох зэрэг өргөн хүрээтэй журмуудыг тогтсон байдаг.⁷⁶ Гэрээ нь Монгол улсад үлдээхээр тохирсон баялгийн хувь хэмжээний тухайд эргэлзээ төрүүлэн агуулгын хувьд маргаантай болжээ. 2013 онд МУ–ын ЗГ нь Гэрээнд өөрчлөлт оруулах оролдлого хийсэн боловч тэр нь далд уурхай байгуулах хоёрдох шатны ажлын санхүүжилт, барилгыг хойшлуулахаас өөр үр дүнд хүрсэнгүй.

3.1 Гурван тал Татварыг тогтворжуулав уу? Аль эсвэл тусгаар улсын бүрэн эрхээс татгалзав уу?

Гэрээний 2 дугаар бүлэг нь “Татварын орчин” нэртэй бөгөөд Оюу Толгойн үйлдвэрлэл, ашигт ажиллагаатай холбоотой татвар ногдуулах зарчмыг тогтоодог. Түүний 1–р зүйлд МУ–ын Татварын ерөнхий хуулийн дагуу Оюу Толгойн үйл ажиллагаанд ногдуулах хэд хэдэн төрлийн татварыг 2009 хэмжээнд тогтворжуулна гэж заасан байдаг. Тэдгээр нь ашиг орлогын татвар, НӨТ, роялти болон бусад татварыг багтаасан хэрэг. Мөн Түркойз Хилл Ресурс ба түүний охин компаниудын хийх гуйвуулгад ногдох суутгал татваруудыг ч 2009 хэмжээнд тогтворжуулахаар заажээ. “Суутгал татвар” гэж Монголд үйл ажиллагаа явуулж буй компаниуд ногдол ашиг, роялти буюу хүүний төлбөрийг гадаадад байрших компанид хийх тохиолдолд суутган үлдээх татварыг хэлж байгаа юм. Жишээлбэл: Оюу Толгой ХХК нь өөрийн хувь нийлүүлэгч Oyu Tolgoi Netherlands B.V. компанид ногдол ашиг төлөх бол Монгол улс түүнээс татвар суутган авах ёстой гэсэн үг.

Ногдол ашиг, роялти болон хүүний төлбөрийг гадаад руу гуйвуулах тохиолдолд Монголын хуулийн дагуу 20%–ийн суутгал татвар төлөх ёстой юм.⁷⁷ Гэвч гадаад орнуудтай байгуулсан Давхар Татварын Хэлэлцээр \ДТХ\–үүдэд уг суутгал татварыг хэлэлцээрт оролцогч орнуудын хооронд хийх төлбөрүүдийн хувьд бууруулахаар тохиролцдог. Жишээлбэл: Монгол улс, Малайзын хооронд байгуулсан ДТХ–ээр хүүний төлбөрийн суутгал татварын хэмжээг 20% бус

76 The Government of Mongolia, Ivanhoe Mines Mongolia Inc LLC, Ivanhoe Mines Ltd, and Rio Tinto International Holdings Limited, Investment Agreement, 6 October 2009, http://www.turquoisehill.com/i/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF.
Авсан 2017–08–08.

77 PricewaterhouseCoopers, Mongolia: Corporate – Withholding taxes, no date <http://taxsummaries.pwc.com/ID/MongoliaCorporate-Withholding-taxes>. Авсан 2017–08–08.

10%-иар тохирсон байдаг.⁷⁸ МУ-ын ЗГ болон Түркойз Хилл Ресурсын тохиролцсон Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээгээр татварыг тухайн үеийн МУ-ын хуульд заасан хэмжээнээс гадна бүр тухайн үеийн ДТХ-үүдэд бууруулж заасан хэмжээнд тогтворжуулах болжээ.

ОУВС-ийн 2012 оны судалгаанд МУ-аас хэд хэдэн оронтой байгуулсан ДТХ нь Монголд төлвөл зохих татвараас зайлсхийх боломжийг гадаадын зарим компаниудад олгож ирснийг нотлон харуулж, эдгээрийн дөрөв нь буюу Кувейт, Люксембург, Арабын Нэгдсэн Эмират Улс (АНЭУ) болон Нидерландтай байгуулсан хэлэлцээрүүд МУ-д татварын орлогоо хамгаалан баталгаажуулахад саад учруулж байгааг тэмдэглэсэн аж.⁷⁹ Монгол Нидерландын ДТХ нь хоёр орны хооронд шилжүүлэх ногдол ашгийн суутгал татвар зарим тодорхой нөхцөл байдалд бүр 0% болж буурахад хэрхэн үйлчилж байгаа ба ийнхүү нөхцөл байдал нь Оюу Толгойн уурхайгаас Оуу Tolgoi Netherlands B.V.-д шилжүүлэх ногдол ашигт ч хамааралтай байж болохыг уг судалгаанд тайлбарлан харуулжээ. Энэ нь Түркойз Хилл Ресурс (өмнө нь Айвэнхоу Майнз)-ын дарга асан Роберт Фридландын хэлж байсныг тайлбарлана биз. 2011 онд ноён Фридланд Түркойз Хилл Ресурс компани нь Монголд явуулах үйл ажиллагаандаа хамгийн бага хэмжээний татвар төлөх болно хэмээн мэдэгдэж, компани нь МУ-ын засаг, түүний дотор Ерөнхийлөгчтэй маш сайн харилцаатай тул Монголоос Канад руу шилжүүлэх ногдол ашигт бараг л тэг татвар төлөх тухай ярьж байжээ.⁸⁰ МУ-аас зөвхөн Нидерланд, АНЭУ-тэй байгуулсан ДТХ-үүдэд суутгал татварыг тэглэх заалт⁸¹ байдаг ба Оюу Толгойн хувьцааг Оуу Tolgoi Netherlands B.V.-д өмчлүүлсэнийг санавал ноён Фридланд чухамхуу Монгол-Нидерландын ДТХ-ийг ашиглан Монголд төлвөл зохих татвараа үлэмж хэмжээгээр бууруулах тухай өгүүлсэн байж таарна.

Дээрх ОУВС-ийн нийтлэлийн мөрөөр МУ-ын ЗГ нь тэрхүү дөрвөн ДТХ-ийг хүчингүй болгох шийдвэрийг дангаараа гаргах тухай мэдэгдсэн.⁸² Ийнхүү өөрийн нутаг дэвсгэрээс гарч буй санхүүгийн урсгалуудад татвар ногдуулах эрхээ сэргээж МУ-ын ЗГ нь татварынхаа орлогыг хянах оролдлого хийсэн. Нидерландтай байгуулсан ДТХ нь 2014 оны нэгдүгээр сард албан ёсоор хүчингүй болсон.⁸³ Гэвч Ройтерс агентлагт өгөх ярилцлагадаа Рио Тинтогийн хэвлэлийн төлөөлөгч болох нэгэн Нидерландад бүртгэлтэй охин компани нь Оюу Толгой ХХК-ийг өмчилдөг ч дээрх Нидерландтай байгуулсан ДТХ хүчингүй болсон явдал Оюу Толгой уурхайтай

78 PricewaterhouseCoopers, Mongolia: Corporate – Withholding taxes, no date <http://taxsummaries.pwc.com/ID/MongoliaCorporate-Withholding-taxes>. Авсан 2017-08-08.

79 IMF, Mongolia: Technical Assistance Report – Safeguarding Domestic Revenue – A Mongolian DTA Model, November 2012, <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2012/cr12306.pdf>. Авсан 2017-11-08 <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2012/cr12306.pdf>.

80 MiningWatch Canada, Mining Mongolia: Ivanhoe, T-shirts, NGOs, and Wikileaks, 5 June 2011, <https://miningwatch.ca/blog/2011/6/5/mining-mongolia-ivanhoe-t-shirts-ngos-and-wikileaks>. Авсан 2017-12-15.

81 IMF, Mongolia: Technical Assistance Report – Safeguarding Domestic Revenue – A Mongolian DTA Model, November 2012, <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2012/cr12306.pdf>. Авсан 2017-11-08.

82 Business Council of Mongolia, Mongolia cancels double-tax contracts, 20 February 2013, <http://mail.bcmongolia.org/en/mongolia-business-news/174-mongolia-cancels-double-tax-contracts>. Авсан 2017-09-10.

83 KPMG, Mongolia Tax Profile, July 2016, <https://home.kpmg.com/content/dam/kpmg/xx/pdf/2016/09/country-tax-profile-mongolia.pdf>. Авсан 2017-08-16.

холбоотой Монголд төлөх суутгал татварын хэмжээнд огт нөлөөлөхгүй гэжээ.⁸⁴ ОТХОГ-нд заасан тогтворжуулалт нь суутгалын татварын хэмжээг 2009 оны түвшинд тогтоосон учир Монгол улсын авсан арга хэмжээ нь Түркоиз Хилл болон Рио Тинто-д нөлөөлөөгүй юм. Дахин тодруулваас, Монголын ЗГ-аас нэгэнт цуцалсан дөрвөн ДТХ нь хүчингүй хэвээр байгаа юм. Гагцхүү Оюу Толгойн хөрөнгө оруулагчид л ОТ Хөрөнгө оруулалтын гэрээг үндэслэн дээрх хэлэлцээрүүдэд заасан таатай нөхцлүүдээс хүртсээр байгаа бөгөөд эдгээр таатай нөхцлийг ийнхүү ашиглах нь зөвхөн Монгол улсын ОТ болон түүний хөрөнгө оруулагчдад татвар ногдуулах эрх хэмжээнд халдаж, харин хэлэлцээрүүдийн бусад оролцогч талын эрх хэмжээнд хамаагүй болж таарна. Эл зохицуулалт нь Оюу Толгойгоос авах татварын орлогод хир хор уршигтай болсон тухай 4 дүгээр бүлэгт өгүүлнэ.

3.2 Орлого тойрсон маргаан – Монгол улс бууж өгөв

2006 онд гэрээ хэлэлцээ хийгдээд хоёр жил болж байх үед МУ-ын ЗГ болон Рио Тинтогийн хоорондын хамгийн том зөрчилдөөн гарч ирсэн. Тэр жил МУ нь зэс, алтны зах зээлийн үнийн өсөлт тодорхой босго давмагц уурхайн компаниудаас гэнэтийн ашгийн нэмэлт татвар авахаар болсон. Энэхүү хууль нь 2006 оны тавдугаар сард батлагдснаас үүдэж Оюу Толгой ХХК-ийн Монголд төлөх татварын хэмжээ нэмэгдэх сургаар Түркоиз Хилл Ресурс (тэр үед Ivanhoe Mines) компанийн биржүүд дээрх хувьцааны үнэ 21%-иар буурсан болно.⁸⁵ Дараа жилүүдэд нь Рио Тинто ба Түркоиз Хилл Ресурс компаниуд Монголд оруулах хөрөнгө оруулалтынхаа нөхцөл болгон гэнэтийн ашгийн татвараас татгалзахаар МУ-ын ЗГ-ыг лоббидсон тухай мэдээлэл тархсан. 2009 онд МУ-ын ЗГ шахалтанд бууж өгч 2011 онд гэнэтийн ашгийн татвар хүчингүй болсон.⁸⁶

2011 онд зарим улс төрчид Оюу Толгой дахь Монголын талын хувь хэмжээг ОТХОГ-г өөрчлөх замаар нэмэгдүүлэхийг ЗГ-аас шаардаж байв. Уурхайгаас олж буй ашгийн хэмжээ өндөр байх тэр үед парламентын зарим гишүүд нь Монголын талын оролцоог 40%-д хүргэх ёстой гэж байв.⁸⁷ Хөрөнгө оруулагчид харин ийнхүү эрүүл бус популист бодлого нь Монгол дахь уул уурхайн өсөлт, тэлэлтийг зогсоох аюултай мэт талбарлаж асуулдлыг үгүйсгэсэн мэдээлэл бий.⁸⁸ Нэг жилийн дараа ЗГ нь татварын орлогыг \$300 сая ам.доллараар нэмэгдүүлэх зорилгоор

84 Reuters, Special report: In tax case, Mongolian is the mouse that roared, 16 July 2013, <https://www.reuters.com/article/us-dutch-mongolia-tax/special-report-in-tax-case-mongolia-is-the-mouse-that-roared-idUSBRE96F0B620130716>. Авсан 2017-08-16.

85 CBC News, Ivanhoe 'surprised' by new Mongolian windfall tax, 15 May 2006, <http://www.cbc.ca/news/business/ivanhoe-surprised-by-new-mongolian-windfall-tax-1.622422>. Авсан 2017-08-18.

86 US Department of State, 2013 Investment Climate Statement – Mongolia, Apr 2013, <https://www.state.gov/e/eb/rls/othr/ics/2013/204697.htm>. Авсан 2017-08-08.

87 Reuters, Mongolia discussing changes to Oyu Tolgoi copper deal –report, 20 Sep 2011, <https://www.reuters.com/article/mongolia-oyutolgoi/mongolia-discussing-changes-to-oyu-tolgoi-copper-deal-report-idUSL3E7KK1T020110920>. Авсан 2017-08-16.

88 Reuters, Mongolia discussing changes to Oyu Tolgoi copper deal –report, 20 Sep 2011, <https://www.reuters.com/article/mongolia-oyutolgoi/mongolia-discussing-changes-to-oyu-tolgoi-copper-deal-report-idUSL3E7KK1T020110920>. Авсан 2017-08-16.

ОТХОГ-г өөрчлөх шийдвэрээ зарласан.⁸⁹ 2006 оноос эхэлсэн байгалийн баялагт тавих төрийн \нийтийн\ хяналтыг чангатгах, байгалийн баялгыг нийгэмд илүү хүртээлтэй болгох үзэл санаагаар уул уурхайн компаниудад ногдуулах татварыг \$340 сая долларт хүргэх хууль батлах гэж оролдсон. Мөн уурхайн зардлын өсөж буй өртөг, түүний тэлэлттэй холбоотой гарч ирэх төрийн өрийн өсөлт ЗГ-ын санааг зовоосон бас нэгэн асуудал байв.⁹⁰ Үүн дээр нэмэгдэж УИХ-аас Оюу Толгойд хийсэн 2013 оны аудитын дүнгээр уурхайн менежментын үйлчилгээний шимтгэл, зардлуудад олон төрлийн өртгийг өсгөн тогтоосон зөрчлүүд илэрсэн болно.⁹¹

Энэхүү зөрчилдөөн нь ЗГ-аас Рио Тинто болон Түркоиз Хиллтэй үүссэн асуудлыг шийдвэрлэх хүсэлтэй байгаагаа мэдэгдтэл 2013 оны арваннэгдүгээр сар хүртэл үргэлжилсэн аж.⁹² Энэ үед Рио Тинто Оюу Толгойн 1700 ажилчныг халчихсан байсан нь ЗГ-ыг уг маргааныг эцэслэх чиглэлд хөтөлсөн бололтой.⁹³ Үүнээс гадна тухий эдийн үнийн уналт, 2012 онд зогссон зарим томоохон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээ нь Монголын эдийн засагт ихээхэн нөлөөтэй⁹⁴ гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүнг бууруулсан нь Рио Тинтотой маргах ЗГ-ын чадавхид нөлөөлсөн байх.

2015 онд МУ-ын ЗГ ба Рио Тинто тохиролцоонд хүрч Оюу Толгойн хоёрдахь шатыг эхлүүлэх боломжтой болсон.⁹⁵ ЗГ-аас тавьсан шаардлагууд биеллээ олоогүй тул 2009 оны ОТХОГ-ний нөхцөлүүд хэвээр хадгалагдав. Рио Тинто, Түркоиз Хилл Ресурс нь ЗГ-аас нэхэмжилсэн 300 сая ам. доллар татварыг биш, харин 30 саяыг нэмж төлөхөөр болов. Мөн Рио Тинто хайлуулах үйлдвэрийн роялтигээс татгалзаж, ЗГ-аас төлөөгүй хэмээнээр шахан шаардсан 10 сарын роялтийг төлөхөө зөвшөөрөв. Нийтэд мэдээлснээр энэхүү гурван зүйл нь нийт 148 сая ам.

-
- 89 The New York Times, Tax Proposal in Mongolia Threatens Rio Tinto Project, 15 Oct 2012, <https://dealbook.nytimes.com/2012/10/15/tax-proposal-in-mongolia-threatens-rio-tinto-project/>. Авсан 2017-04-04.
- 90 Reuters, UPDATE 1-IMF delays Mongolia bailout due to banking requirements for foreign firms, 2 May 2017, <http://www.mongolia-mining.org/news/39/rio-tinto-close-to-6bn-finance-deal-for-mongolian-mine>. Reuters, Mongolia wants to resolve mine dispute with Rio Tinto by early 2014, 21 Nov 2013, <http://www.reuters.com/article/mongolia-economy-idUSL4N1I41PL>; <http://www.reuters.com/article/mongolia-rio-idUSL4N0J605I20131121>. Авсан 2017-04-04.
- 91 http://www.oefse.at/fileadmin/content/Downloads/tradeconference/Jargalsaikhan_Investment_Treaties_Between_Mongolia_and_EU_states_-_Implications_for_Mongolias_Development_Prospects.pdf Тогтвортой хөгжлийн стратегийн хүрээлэнгээс Оюу Толгойн тухайд ийнхүү тайлбар өгчээ: “Дүгнэвээс, энэхүү Хамтарсан үйлдвэрийг байгуулах тухай Хувьцаа эзэмшигчдын гэрээ (ХЭГ) нь Монголыг Оюу Толгойн үнэ цэнийн сүлжээнээс бүрэн хасахын зэрэгцээ үлэмж хэмжээний үүргээр дарж, өөрийгөө болон стратегийн нөөц баялгаа хамгаалах аливаа эрхзүйн арга гарцгүй болгожээ. Гэрээ нь Оюу Толгойн бүхий л ашиг өртгийг, түүний дотор Монголын 34% хувьцааны эдийн засгийн үнийг 100%-иар Түркоиз Хилл Ресурст шилжүүлэн Монголыг дампууралд хүргэхүйц өртэй хийгээд эрх мэдэлгүй, хяналтын арга хэрэгсэлгүй үлдээв.⁵⁰ ХЭГ нь Монголын Засгийн газрын аиг сонирхлыг үл харгалзан Монголыг өрөнд унагаасан аж.”
- 92 Reuters, Mongolia wants to resolve mine dispute with Rio Tinto by early 2014, 21 Nov 2013, <https://www.reuters.com/article/mongolia-rio/mongolia-wants-to-resolve-mine-dispute-with-rio-tinto-by-early-2014-idUSL4N0J605I20131121>. Авсан 2017-04-04.
- 93 Reuters, Mongolia wants to resolve mine dispute with Rio Tinto by early 2014, 21 Nov 2013, <https://www.reuters.com/article/mongolia-rio/mongolia-wants-to-resolve-mine-dispute-with-rio-tinto-by-early-2014-idUSL4N0J605I20131121>.
- 94 Mining Weekly, Turquoise Hill rejects Mongolian review of mining contract, 15 Oct 2012, http://www.miningweekly.com/article/turquoise-hill-rejects-review-mongolian-of-mining-contract-2012-10-15/rep_id:3650. Авсан 2017-10-06.
- 95 Mining.com, Rio Tinto closes \$4.4 billion financing deal for Oyu Tolgoi mine, 15 Dec 2015, <http://www.mining.com/rio-tinto-closes-4-4-billion-financing-deal-for-oyu-tolgoi-mine/>. Авсан 2017-04-04.

доллар болсон нь ЗГ-ын анх нэхэмжилсэн дүнгийн талд нь ч хүрээгүй аж.⁹⁶ Рио Тинтогийн хэвлэлийн төлөөлөгч дүгнэхдээ 2009 оны ОТХОГ-ний нөхцлүүдийг хадгалж үлдээхэд хамгийн бага үнийг төллөө гэсэн байдаг⁹⁷. Түркоиз Хилл Ресурс нь 155 сая ам. долларын татвар нэмж төлөх нэхэмжлэлийг Монголын Татварын Ерөнхий Газраас авсан тухайгаа 2018 оны 1-р сарын 15-нд мэдээлэхдээ нарийн төлөв ярихгүйгээр нэхэмжлэлийг судалж байна гэжээ.⁹⁸

3.3 Оюу Толгойн хэлэлцээн дэх МУ-ын Засгийн газрын үүрэг оролцоо

Гарын үсэг зурахад МУ-ын ЗГ-ыг төлөөлж оролцсон өндөр албан тушаалтан нь Сангийн сайд Сангажавын Баярцогт байв. Ноён Баярцогт Эрдэс баялаг, эрчим хүчний сайд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын хамт МУ-ын ЗГ-ыг төлөөлж хэлэлцээг явуулж байв.⁹⁹

2013 онд Оффшор лийкс мэдээллийн сангаас гарсан мэдээлэл болон дагалдах судалгаа зэрэг нь ноён Баярцогт Швейцар дахь банкны нуугдмал дансанд нэг сая ам.доллар эзэмшдэг ба тэр нь түүний татварын мэдүүлэгт тусгагдаагүйг илрүүлэв. Ноён Баярцогт үүссэн байдлыг тайлбарлахдаа, холбогдох мөнгөний 200,000 ам. доллар нь л өөрийнх нь бөгөөд гэр бүлийн буудайн бизнесээс гаралтай гэж мэдээлсэн байдаг. Дансыг олон улсын хувьцааны арилжаанд оролцох зорилгоор нээсэн, удахгүй хаана гэжээ.¹⁰⁰ Энэ 1 сая ам. долларын хөрөнгийг ноён Баярцогтын хашиж байсан сангийн сайдын албан тушаалтай холбосон яриа цахим сүлжээгээр өргөн явагдсан бололтой.¹⁰¹ Хэдий тийм ч ноён Баярцогтын Швейцар банкин дахь дансны 1 сая ам.доллар ямар нэгэн байдлаар Оюу Толгой эсвэл авилгын хэрэгт холбоотой болохын аливаа нотолгоо үгүй байгаа юм байна.

-
- 96 The Sydney Morning Herald, Rio Tinto's Mongolian copper mining dream lives on, but at a cost, 19 May 2015, <http://www.smh.com.au/business/mining-and-resources/rio-tintos-mongolian-copper-mining-dream-lives-on-but-at-a-cost-20150519-gh53bn.html>. Авсан 2017-08-08.
- 97 Reuters, UPDATE 1-IMF delays Mongolia bailout due to banking requirements for foreign firms, 2 May 2017, <http://www.reuters.com/article/mongolia-economy-idUSL4N1I41PL>. Авсан 2017-04-04.
- 98 Turquoise Hill Resources, Oyu Tolgoi receives Tax Act from Mongolian Tax Authority, 15 Jan 2018, http://www.turquoisehill.com/s/news_releases.asp?ReportID=813054. Авсан 2018-01-10.
- 99 The Government of Mongolia, Ivanhoe Mines Mongolia Inc LLC, Ivanhoe Mines Ltd, and Rio Tinto International Holdings Limited, Investment Agreement, 6 Oct 2009 http://www.turquoisehill.com/i/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF. Авсан 2017-08-08.
- 100 International Consortium of Investigative Journalists, Disclosure of secret offshore documents may force top Mongolian lawmaker to resign, 3 Apr 2013, <https://www.icij.org/investigations/offshore/disclosure-secret-offshore-documents-mayforce-top-mongolian-lawmaker-resign/>. Авсан 2017-10-16.
- 101 The Mongolist, Continuing Analysis: S. Bayartsogt and the ICIJ Report, 5 Apr 2013, <http://www.themongolist.com/blog/parliament/66-continuing-analysis-s-bayartsogt-and-the-icij-report.html>. Авсан 2017-10-15.

Энэхүү илчлэлийн ач холбогдол нь МУ-ын ЗГ-т татварын асуудал эрхэлсэн дээд албан тушаалтан болох Сангийн сайд нь гадаадад данс нээсэн, түүнд хийсэн мөнгөө татварын албанд мэдүүлээгүй, өөрийн улсын татвараас зугтсан байж болзошгүйг харуулсанд байгаа юм. Ноён Баярцогт өөрийгөө өмгөөлж ярихдаа тэр 1 сая ам. долларын мөнгөөр орлого олоогүй, мөнгө нь хөдөлгөөнгүй хадгалагдаж байсан тул татвар ногдох орлогоор мэдээлээгүй гэх санаа гаргасан аж.¹⁰² Нэг сая ам. долларын мөнгөн хөрөнгийг Швейцарийн банкны дансанд хөдлөхгүйгээр, орлого олохгүйгээр хийчихээд суух нь эдийн засгийн утга багатай явдал гэж хэлэх үндэслэлтэй юм. Монгол улсын татварын асуудал хариуцсан дээд эрх мэдэлтэн татвар төлөх үүрэгтээ сайнаар хэлвэл хариуцлаггүй, муугаар хэлвэл луйвардах санаатайгаар хандсаныг харвал Монголын ЗГ нь Оюу Толгойн хэлэлцээ хийхдээ ард түмнийхээ ашиг сонирхлыг эрхэмлэх чадвартай байсан эсэхийн тухай асуулт зүй ёсоор тавигдах болж байгаа юм.

102 International Consortium of Investigative Journalists, Disclosure of secret offshore documents may force top Mongolian lawmaker to resign, 3 Apr 2013, <https://www.icij.org/investigations/offshore/disclosure-secret-offshore-documents-mayforce-top-mongolian-lawmaker-resign/>. Авсан 2017-10-16.

4 Татвараас зайлсхийх ба татварыг хэт бууруулах нь

Оюу Толгойн уурхайн ажиллагааг олонх хувьцааны өмчлөгч Канадын Түркойз Хилл Ресурс ХХК¹⁰³ компаниас олгосон зээлээр санхүүжүүлж байгаа ба Түркойз Хилл Ресурс ХХК-г Рио Тинто эзэмшдэг. Түркойз Хилл Ресурс ХХК нь Оюу Толгойг санхүүжүүлэх хөрөнгөтэй болмогц түүнийгээ Люксембург дахь охин компани Мовель SARL-ын мэдэлд шилжүүлдэг байна.¹⁰⁴

2012 оноос Мовель нь энэ мөнгийг жил бүр Оюу Толгой ХХК-ийн шууд өмчлөгч болох Нидерландын Оюу Tolgoi Netherlands BV компанид зээлээр олгож, Оюу Tolgoi Netherlands BV нь ойролцоогоор ижил дүнгээр Оюу Толгой ХХК-ийг мөн жил бүр зээлжүүлж, түүгээр нь Оюу Толгой ХХК уурхайн үйл ажиллагаагаа явуулж иржээ. Оюу Толгойн санхүүжилт ийнхүү бүтэцтэй зохион байгуулагдсан нь санхүүгийн сэдэлттэй ба Түркойз Хилл ба түүний групп компаниудад Монгол, Канадын аль алины татвараас зугтах боломжийг олгодог байна. Доорхи хэсэгт ямар зорилгоор ийм санхүүгийн бүтцийг зохиож, яаж татвараас зайлсхийж буй байдал нь Монгол ба Канад дээр хэрхэн тусч байгааг харуулна.

4.1 Люксембургээс ирэх зээл

Түркойз Хилл Ресурс ХХК-иас Оюу Толгой ХХК-д олгож буй зээл нь Люксембург дахь охин компани Мовель SARL-аар дамжин ирнэ. Зээлийн зарим хэсгийг Мовель (Люксембургээс) Оюу Толгой ХХК (Монголд)-д өөрөө шууд өгнө, харин зарим хэсгийг Нидерланд дахь Түркойз Хилл Ресурс ХХК-ийн охин компани Оюу Tolgoi Netherlands BV дамжуулж Оюу Толгой ХХК-д хүргүүлнэ. Мовель-ээс ирэх Оюу Толгой ХХК-ийн санхүүжилтийг ийнхүү шууд (Люксембургээс) болон шууд бус (Нидерландаас) хоёр аргаар гүйцэтгэж байна. Хамгийн ойр (2015 он) ил нийтлэгдсэн санхүүгийн мэдээллээс харвал уг санхүүжилтийн бүтцийг аль 2011 оноос хойш хэрэглэж иржээ. Зээлийн тоон мэдээг дорхи хүснэгтүүдээс харж болно.

103 Turquoise Hill Resources, Oyu Tolgoi: Advancing value, creating options, Aug 2017, <http://www.turquoisehill.com/i/pdf/ppt/Presentation-Aug-2017-FINAL.pdf>. Авсан 2018-01-02.

104 Turquoise Hill Resources, MD&A and Financial Statements, 31 Dec 2016, <http://www.turquoisehill.com/i/pdf/2016-12-31-TRQ-FS-and-MDA.pdf>. Авсан 2017-04-10; Turquoise Hill Resources, MD&A and Financial Statements 2015, 31 Dec 2015, <http://www.turquoisehill.com/i/pdf/TRQ-Q4-2015.pdf>. Авсан 2017-04-10.

Хүснэгт 1 Люксембург(Мовель)-ээс Монгол(Оюу Толгой ХХК)-д шууд олгосон зээл х US\$1,000¹⁰⁵

	2011	2012	2013	2014	2015	2016	Зээл\үлдэгдэл Зээлийн дундаж, хүүний Дүн
Оюу Толгой ХХК-аас Мовель S.A.R.L.-д төлөх өр							
Зээл\үлдэгдэл	3,473,463	3,092,822	3,302,462	2,995,437	2,697,755	3,176,169	3,112,388
Хүү	120,438	197,803	209,668	220,003	184,319	n.a.	932,229

Дээрх хүснэгт Люксембург дэх Мовель-ээс Монгол дахь Оюу Толгой ХХК-ийн уурхайд ирсэн зээлийн урсгалыг харуулна. 2011–2015 онуудын хугацаанд зээллэгийн дундаж 3.1 тэрбум ам.доллар, харин Оюу Толгой ХХК-иас Мовель SARL-д төлөх хэмжээ нь 932 сая ам.доллар болсон байна. Энэ 932 сая ам.доллар хүүний зардал нь Оюу Толгой ХХК-ийн татвар ногдуулах ашгийн хэмжээг бууруулж Монголд үлдэх татварын бааз, татварын орлогыг багасгаж байна. Рио Тинто, Түркойз Хилл Ресурс нь энэхүү баримтуудын талаар өгсөн саналдаа Мовель компани Оюу Толгой ХХК-д шууд зээл олгохоо больсон гэж мэдэгдэв.

Байгуулагдсанаас хойш өөрийн бүртгэлийн баримт бичигт Мовель нь нэг хагас цагийн ажилтантай, харин Oyu Tolgoi Netherlands BV огт ажилтангүй байна. Энэхүү байдал нь хоёр компани нь жил тутамд тэрбум гарсан долларын зээллэгийн асуудлыг хариуцдаг байдалтай огт нийцэхгүй байгаа юм. Oyu Tolgoi Netherlands B.V.-ийн менежментийг Нидерландын Intertrust гэх итгэлцлийн компани хариуцдаг аж¹⁰⁶. Түркойз Хилл Ресурс-ийн энэ хоёр охин компани нь ажилтангүй гэх нь компаниуд нь зөвхөн цаасан дээр орших “шуудангийн хайрцаг” компани маягаар бодит эдийн засгийн ажиллагаа явуулдаггүйг нотлож байгаа болно.

Хүснэгт 2 Люксембург (Мовель SARL)-ээс Нидерланд (Oyu Tolgoi Netherlands BV)-аар дамжуулан Монгол (Оюу Толгой ХХК)-д шууд бус байдлаар олгож буй зээл х US\$1,000¹⁰⁷


	2012	2013	2014	2015	2016	Зээлийн дундаж, хүүний Дүн
Оюу Толгой ХХК-аас Oyu Tolgoi Netherlands BV (NL)-д төлөх өр						
Зээл\үлдэгдэл	2,093,003	3,529,244	3,905,517	4,120,431	n.a.	3,412,049
Хүү	89,585	198,241	246,273	265,734	n.a.	799,833
Oyu Tolgoi Netherlands (NL)-аас Мовель SARL (LUX)-д төлөх өр						
Зээл\үлдэгдэл	2,433,884	3,598,532	3,924,163	4,188,308	n.a.	3,536,222
Хүү	103,860	215,848	245,631	264,145	n.a.	829,483

105 Movele Sarl, 2011–2016 онуудын жилийн бүртгэл. Эдгээр жилийн бүртгэлүүдийг Люксембургийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хуудаснаас авч болно: <https://www.rcsl.lu/>.

106 Oyu Tolgoi Netherlands BV, like Turquoise Hill Netherlands Coöperatief, is registered at Prins Bernhardplein 200, the address of Intertrust. Oyu Tolgoi Netherlands BV, 2015 annual report, 22 Dec 2016, www.kvk.nl. Авсан 2017-09-06 6 September 2017. Turquoise Hill Netherlands Coöperatief U.A., 2015 Annual Report, 22 Dec 2016, www.kvk.nl. Авсан 2017-09-06.

107 Oyu Tolgoi Netherlands BV, annual reports for the years from 2012 until 2016. These reports can be retrieved from the Dutch Chamber of Commerce: <https://www.kvk.nl/zoeken/>.

Зураг 4 Оюу Толгойн санхүүжилтийг хийх явцад татвараас зугтах бүтэц¹⁰⁸



Дээрх хүснэгтээс харахад 2012–2015 онуудад Оюу Толгой ХХК-иас Oyu Tolgoi Netherlands BV-д төлөх өр, хүүний хэмжээ нь Оюу Tolgoi Netherlands BV-аас Мовель S.A.RL-д төлөх хэмжээтэй маш ойр байна. Энэ нь Нидерланд дахь охин компанийг “татварын диваажин” хэмээх Люксембургийн охин компани Мовель-ээс Оюу Толгой ХХК-д олгох зээллэгийн зөвхөн санхүүгийн суваг болгож ашигласныг харуулж байгаа юм. Аль аль зээлийн дундаж үлдэгдэл 3.5 тэрбум ам.доллар, дөрвөн жилд бодогдсон хүүний төлбөр 800 сая ам.долларын хэмжээнд байна. Хүүний төлбөр нь Оюу Толгой ХХК-ийн татвар ногдох ашгийн хэмжээг бууруулан Монгол улсын татварын орлогыг багасгаж, Люксембург дэх Мовель-ийн татвар ногдох ашгийг нэмэгдүүлж байгаа юм.

Оюу Толгой ХХК-ийн 800 сая ам. доллар бүхий хүүний төлбөр нь одоо болон цаашид үргэлжилвээс ирэх он жилүүдэд компанийн татвар ногдох орлогыг дүйцэхүйц хэмжээгээр бууруулсаар байх болно. Үүгээр компанийн татварын суурь хумигдаж, Монгол нь татварын орлогын алдагдал хүлээхээр байна.¹⁰⁹ Товчхон хэлвэл, Оюу Толгой нь татвар ногдох орлогоо багасгаж харуулах боломжтой учраас Монголын хуулиар тотоосон компанийн орлогын 25%-ийн

татварт бараг л өртөхгүй болов уу. Монголын ЗГ-ын ОТ дахь 34% -ийг бодолцвол Оюу Толгой ХХК-аас хуваарилах ногдол ашгийн гуравны нэг нь ЗГ-т очих учиртай юм. Гэвч компанийн орлогыг хүүний төлбөрүүд буруулж байгаа учраас дээрх ногдол ашгийг хууварилан олгох нь асуудалтай болно. Харин Люксембург дэх охин компани Мовель-ийн хүүний орлогыг Түркоиз Хилл Ресурс дан ганцаараа эзэмшинэ.

108 Оюу Tolgoi Netherlands BV, 2012–2016 онуудын жилийн тайлангууд. Эдгээрийг Нидерландын Худалдааны танхимын вэб хуудаснаас татаж болно: <https://www.kvk.nl/zoeken/> (website in Dutch). Мовель Sarl, 2011–2016 онуудын жилийн тайлангууд-ыг Люксембургийн Худалдааны танхимаар дамжуулан дараах хаягаар олж болно: <https://www.rcsl.lu/>.

109 Энэ дүгнэлт үнэн зөв байх үндэслэлтэй боловч Оюу Толгой ХХК нь ашиг алдагдлын тайлангаа нийтэлдэггүй, ил тод бус учраас нотлоход бэрхшээлтэй байна. ОТ нь уурхайн барилгын ажил эхэлсэн цагаас алдагдалтай байгааг Түркоиз Хилл Ресурс, Рио Тинто нар уг судалгаанд өгсөн хариу саналдаа мэдэгдсэн. ОТ-йн хүүний төлбөр компанийн татвар ногдох орлогыг багасгах эсэх нь ОТ өнөөгийн алдагдлаа ирээдүйн орлогоор нөхөж болдог татварын хөнгөлөлтүүдийг хэрхэн ашиглахаас хамаарна. Монголын татварын хуульд алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг 8 жил хүртэл тогтоосныг харвал энэхүү хөнгөлөлтийг ажиглаж таарах гээд байгаа юм.

Дээр дурдсан зээлүүд нь татвараас зугтах дараах бүтэц зохион байгуулалтыг Зураг 4-т харуулснаар нотлож байна.

Нидерланд дахь Oyu Tolgoi Netherlands BV нь Мовель-ээс авсан зээлдээ Оюу Толгой ХХК-д өөрийн олгосон зээлийн хүүнээс илүү өндөр хүү төлсөн нь энэ компани нь зөвхөн санхүүжилтийн суваг болсныг илчилж байна. Тэгээд ч 2012–2015 онуудад Нидерланд улсад ашиг орлогын татвар огт төлөөгүй байдал нь үүнийг бүр баталгаажуулж байгаа юм.

OT Netherlands BV “хоршоо” хэлбэрээр бүртгэгдсэн нь Нидерландын энэ сувгийг ногдол ашгийн болон хөрөнгө борлуулсны орлогын татвараас зайлсхийхэд ашиглах боломж олгож байгаа юм. Түркойз Хилл Ресурс компани нь хоршооны эрхзүйн байдлыг ашиглаж Нидерландын ногдол ашгийн татвараас зугтаж ирсэн байх магадлалтай.¹¹⁰ Цаашилбал, Оюу Толгой уурхайг аливаа учраас зарж худалдахад хүрвэл Рио Тинто, Түркойз Хилл Ресурс оронд нь уурхайн өмчлөгч болох OT Netherlands BV охин компаниа зарж болох юм. Ингэснээр Монголын хуулиар заасан хөрөнгө борлуулсаны орлого буюу уурхайг анх авсан үнэ болон зарсан үнийн зөрүүгээс татах татварыг төлөхгүй өнгөрнө.

Шигтгээ 2 Үндэстэн дамнасан корпорацууд бүтцэт шинжтэй татвараас зайлсхийсэн талаарх олон удаагийн мэдээллүүд

Сүүлийн жилүүдэд хэвлэлийнхэн үндэстэн дамнасан корпорацууд татвараас зайлсхийж буй тухай ихээхэн нийтлэх болсон бөгөөд уг мэдээллийн нэгэн эх сурвалж нь татвараас зайлсхийлтийг өөрийн үзүүлдэг зөвлөх буюу бүртгэлийн үйлчилгээгээр өөгшүүлсэн компаниудаас удаа дараалан алдагдсан тоо баримтууд байдаг. Саяхны томоохон жишээ гэвэл дэлхийн олон алдартан, улстөрийн зүтгэлтэн, удирдагч, нэрт компани аж төрж буй орнуудыхаа татварын журмыг үл ойшоон бүтцэт шинжтэй татвараас зайлсхийлтэд автсаныг нотолсон Панамын¹¹¹ болон Парадайз¹¹² баримт бичгүүд юм. Татвараас зайлсхийх үйлдэл олон улсын хэмжээнд тархахад төрүүд, ялангуяа ЕХ дахь татварын диваажин орнууд хэрхэн үүрэг гүйцэтгэж ирснийг эдгээр баримт бичгүүд тодорхой харуулсан аж.

110 Татвараас зайлсхийх энэ арга зам нь 2018 оны 1-р сар хүртэл үйлчилсэн бөгөөд хоршоодыг энэхүү татвараас чөлөөлөх зохицуулалтыг хуулиар үгүй болгосон аж. Гэвч Нидерландын засгийн газар ногдол ашгийн татварыг бүр мөсөн устгах төлөвлөгөөтэй байгааг харгалзвал Рио Тинто нь Монголд олсон орлогыг Канадад шилжүүлэх замд татвараас чөлөөлж авахын тулд тус улсад байгаа энэ сувгаа хэвээр хэрэглэх боломжтой юм. <https://meijburg.nl/nieuws/belastingplan-2018-dividendbelasting>. Авсан 2017-10-10 <https://www.kabinetformatie2017.nl/documenten/publicaties/2017/10/10/regeerakkoord-vertouwen-in-de-toekomst>. Авсан 2017-12-04.

111 International Consortium of Investigative Journalists, Panama Papers <https://panamapapers.icij.org/>. Авсан 2017-12-30.

112 International Consortium of Investigative Journalists, Paradise Papers <https://www.icij.org/investigations/paradise-papers/>. Авсан 2017-12-30.

◉ Шигтгээ 2 Үндэстэн дамнасан корпорацууд бүтцэт шинжтэй татвараас зайлсхийсэн талаарх олон удаагийн мэдээллүүд

Европын холбооны хүрээнд өрсөлдөөний шударга байдал алдагдахад хүргэхүйц төрийн зохицуулалтыг “хууль бус татаас” гэж нэрлэдэг бөгөөд энэ хууль бус татаасыг хэрэглэх хандлага байсаар байна¹¹³. ЕХ нь гишүүн хэд хэдэн орон, тухайлбал Нидерланд, Люксембург, Ирланд зэрэг улсад хандаж тэнд бүртгэлтэй нэр бүхий корпорацуудад ахиу татвар ногдуулахыг уриалахдаа өнөө үйлчилж буй татварын журам нь хууль бус татаас болж байгааг заасан нь үүний нотолгоо юм. Иймээс энэхүү судалгаанд яригдах татвараас зайлсхийлтийг зөвхөн Рио Тинто, Оюу Толгойд хамаатайгаар бус, харин үндэстэн дамнасан корпорацууд хууль ёсны бүтцэт, зохицуулалт эсвэл хуулийн цоорхой зэргийг ашиглан орлогоо татварын диваажин орнууд руу шилжүүлдэг, татвар төлбөрөө багасгадаг, үүгээрээ улс орнуудаас иргэддээ хүргэх эрүүл мэнд, боловсрол зэрэг үндсэн үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэрийг хорогдуулж буй ерөнхий асуудлын хүрээнд харж ойлгох хэрэгтэй.

Уул уурхайн салбар нь татвар төлөхөөс зугтах нарийн арга мэх хэрэглэдгээрээ нэрд гарсан аж.¹¹⁴ Тэдний гарт менежментийн төлбөр болон эрдэс баялгийн арилжааны үнэ шилжүүлэлт¹¹⁵, мөн валют хоорондын банкны хүүний своп гэгч бүдэг битүүлэг хэрэгслүүд олон байдаг.¹¹⁶ Эдгээр арга нь үйл ажиллагаа явуулж буй улсад зардлаа хөөрүүлж орлогоо бууруулах, харин орлогын татвар багатай улсад орлогоо нэмэгдүүлэхэд чиглэдэг юм. Өнөөгийн байдлаар Рио Тинто татвар багатай Сингапур луу үнэ шилжүүлж Австралийн татвараас зайлсхийсэн гэх үндэслэлээр Австралийн засгийн газраас гаргасан 360 сая ам.долларын нэхэмжлэлийг заргалдаж байгаа аж.¹¹⁷ Оюу Толгой ХХК нь жилийн тайлан тэнцлээ нийтлэх үүрэг хүлээдэггүй учраас компанийн санхүүгийн баримт бичигтэй танилцаж ийм арга хэрэглэсэн эсэхийг нь тогтоох бололцоогүй юм.

113 European Commission, State aid Cases, http://ec.europa.eu/competition/state_aid/register/. Авсан 2017-01-10.

114 Natural Resource Governance Institute, Preventing Tax Base Erosion in Africa: a Regional Study of Transfer Pricing Challenges in the Mining Sector, Jul 2016, https://resourcegovernance.org/sites/default/files/documents/nrgi_transfer-pricing-study.pdf. Авсан 2018-01-02.

115 Publish What You Pay, Many ways to lose a billion, Jun 2017, <http://www.publishwhatyoupay.org/wp-content/uploads/2017/07/PWYP-Report-ManyWaysToLoseABillion-EN-INTERACTIVE.pdf>. Авсан 2018-01-02.

116 ABC News, The tax trick big miners use to avoid paying millions, 6 Nov 2017, <http://www.abc.net.au/news/2017-11-06/ato-investigating-multinationals-amid-paradise-papers-leak/9075642>. Авсан 2018-01-02.

Australian Taxation Office, Arrangements involving related party foreign currency denominated finance with related party cross currency interest rate swaps, 26 Apr 2016, <http://law.ato.gov.au/atolaw/view.htm?docid=%22TPA%2FTA20163%2FNAT%2FATO%2F00001%22>. Авсан 2018-01-02.

117 Financial Times, Rio Tinto to fight \$360m Australian tax bill, 5 Apr 2017, <https://www.ft.com/content/676d74c0-1a11-11e7-bcac-6d03d067f81f>. Авсан 2017-12-10.

4.2 Люксембург дахь татварын тохиролцоо: Канадын татвараас зайлсхийх нь

Өмнөх хэсэгт Түркоиз Хилл Ресурс компани нь Монгол дахь Оюу Толгой уурхайн санхүүжилтийг Люксембург дахь “татварын диваажин”-д байршуулсан “шуудангийн хайрцаг” төдий охин компаниар дамжуулан хийж буй тухай өгүүлсэн. Ийнхүү “шуудагийн хайрцаг” компаниудыг ашиглах нь зөвхөн өөр улсын татвараас зугтах санаархалтай холбоотой байдаг нь тодорхой. 2011 болон 2015 онуудад Люксембургийн хуулиар компанийн ашиг орлогын татвар 28.8% ба 29.2% тогтсон хэмжээтэй байсан.¹¹⁸ Гэвч Люксембургийн татварын албадууд нутагт нь компани бүртгүүлэх сонирхолтой этгээдүүдэд татварын урамшуулал, хөнгөлөлт үзүүлдэг талтай. 2014 онд Lux leaks¹¹⁹ гэх мэдээлэл задарснаар PricewaterhouseCoopers гэгч нягтлан бодох, бүртгэлийн компанийн харилцагч компаниуд Люксембургийн татварын албаны тусгай шийдвэрээр хөнгөлөлт авч байсан нь илэрсэн. Зарим тохиолдолд “тайтгаруулах захидал” гэж нэрлэх ийнхүү шийдвэрээр PricewaterhouseCoopers-ийн харилцагчид бүр ашиг орлогын 1 хувийн татвар төлөх хөнгөлөлт эдэлж байжээ.¹²⁰

Мовель-ийн төлсөн татварыг харвал Люксембургийн татварын албатай яг тийнхүү тусгай тохиролцоонд хүрсэн мэт санагдана. Дорхи хүснэгтэд Мовель-ийн 2010–2016 оны татвараас өмнөх ашиг, ашиг орлогын татварын зардал, төлсөн татварын бодит хэмжээг харуулна. Татварын бодит хэмжээ гэж компанийн жинхэнэ төлөх татварыг ерөнхийлөн хуульчилсан утгаар бус, харин засгаас тухайлан зөвшөөрсөн татварын хөнгөлөлт зэрэг тусгай зохицуулалтуудыг харгалзан тооцоолсон хэмжээ байдаг бөгөөд үүнийг Мовель-ийн хувьд түүний орлогын татварыг татварын өмнөх ашгаар хувааж тооцоолов.

Хүснэгт 3 Мовелийн татварын зардал ба Люксембургийн татварын бодит хэмжээ х US\$1,000¹²¹

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Дүн
Татварын өмнөх ашиг	-800	120,234	301,282	425,260	465,438	449,848	353,952	2,116,913
Төлсөн татвар	0	0	0	58	15,566	15,033	58,000	88,656
Татварын бодит хэмжээ	0.0%	0.0%	0.0%	0.01%	3.34%	3.34%	16.39%	4.19%

118 KPMG, Corporate tax rates table, <https://home.kpmg.com/xx/en/home/services/tax/tax-tools-and-resources/tax-rates-online/corporate-tax-rates-table.html>, Авсан 2017-12-05.

119 International Consortium of Investigative Journalists, Luxembourg Leaks, <https://www.icij.org/investigations/luxembourg-leaks/6>. Авсан 2017-12-30.

120 The International Consortium of Investigative Journalists, Leaked Documents Expose Global Companies' Secret Tax Deals in Luxembourg, 5 Nov 2014, <https://www.icij.org/project/luxembourg-leaks/leaked-documents-expose-global-companies-secret-tax-deals-luxembourg>. Авсан 2017-07-03; The Guardian, Luxembourg tax files: how tiny state rubberstamped tax avoidance on an industrial scale, 5 Nov 2014, <https://www.theguardian.com/business/2014/nov/05/-spluxembourg-tax-files-tax-avoidance-industrial-scale>. Авсан 2017-07-03.

121 Мовель- 2010–2016 онуудын жилийн тайлан балансууд: <https://www.rcsl.lu/>.

Хүснэгтээс 2010–2016 онуудад Мовель 2.1 тэрбум ам.долларын ашиг олж, 89 сая ам.долларын буюу 4.31% –ийн ашгийн татвар төлсөн харагдаж байна. Мовель-ийн хийсэн ашиг бараг тэр чигээрээ Монголд Оюу Толгой ХХК-д шууд буюу шууд бусаар олгосон зээлийн хүүний төлбөрөөс бүрдсэн мэт харагдаж байна. Үүнээс Мовель компанийг Люксембургэд бүртгүүлсэн зорилго нь тэдний маш их хөнгөлөлттэй татварын бодит хэмжээг ашиглах, улмаар Түркойз Хилл Ресурс группын татварын зардлыг үлэмж хэмжээгээр багасгахад оршиж байсан нь тодорхой боллоо.

Татвараас зугтахгүйгээр Канад дахь төв компаниас Оюу Толгой ХХК-д шууд зээл олгох альтернатив хувилбар бий.¹²² Канад дахь компани нь өөрөө Люксембург ба Нидерландтай ямар нэгэн шууд холбоо үгүй гэдгээр ойлгож, мөн түүнчлэн татварын хөнгөлөлт, урамшууллыг тэгшитгэлээс гаргавал тэгэх нь логикт нийцтэй хамгийн зөв сонголт болох байсан юм. Хэрэв Оюу Толгойн уурхайн зээлийн санхүүжилтийг Түркойз Хилл Ресурс төв компани хийсэн бол авах хүүний орлого нь төв компанийн ашиг болж Канадын татварт хамрагдах болно. 2010–2015 онуудад Канадын ашиг орлогын татвар нь 31%-иас 26.5%-ийн хэмжээнд хэлбэлзэж байв. Доорхи хүснэгтээр Түркойз Хилл Ресурс компани зээлийг шууд олгосон тохиолдолд Канадад төлөх байсан татвар, харин Люксембург дахь “шуудангийн хайрцаг” Мовель компаниар дамжуулснаар хэдий хэмжээний татварын төлбөрөөс мултарсныг харуулна.

Хүснэгт 4 Канадын ашиг орлогын татварын алдагдал ба Мовель-г ашиглан зайлхийсэн татварын зардал х US\$1,000¹²³

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Дүн
Татварын өмнөх ашиг	-800	120,234	301,282	425,260	465,438	449,848	353,952	2,116,913
Канадын татварын хэмжээ ¹²⁴	31%	28%	26%	26%	26.5%	26.5%	26.5%	26.6% (дундаж)
Канадын алдсан татвар	0	33,666	78,333	110,568	123,341	119,210	93,797	558,914
Мовелийг ашиглан хэмнэсэн	0	33,666	78,333	110,510	107,776	104,177	35,798	470,258

Хэсэгчлэн төрийн санхүүжилттэй энэхүү Оюу Толгой ХХК-д олгох зээлийг Канадын Түркойз Хилл Ресурс төв компаниас олгосон бол Канадын татварын албадууд нэмэлт 2.1 тэрбум ам.долларын ашигт татвар ногдуулах боломжтой байх байсан юм. Канадын татварын тогтсон хэмжээний дагуу Түркойз Хилл Ресурсийн татварт хамрагдах орлогын бааз ийнхүү нэмэгдсэнээр Канадын татварын орлого 558.9 сая ам.доллараар нэмэгдэх тооцоо гарч байна. Энэхүү зохиомол тооцоогоор Түркойз Хилл Ресурс татвараас зугтах бодлого хэрэгжүүлээгүй тохиолдолд тэрээр нэмэлт 470 сая ам.долларын татвар төлөх байж. Харин татвараас зугтах

122 Turquoise Hill Resources, Contacts & Offices, http://www.turquoisehill.com/s/contacts_and_offices.asp.
Авсан 2017-07-03.

123 Мовель –ийн 2010–2016 оны жилийн тайлангаас. Канадын татварын хэмжээ <https://home.kpmg.com/xx/en/home/services/tax/tax-tools-and-resources/tax-rates-online/corporate-tax-rates-table.html>.

124 Энэхүү татварын хэмжээ нь Канадад тухайн хугацаанд тогтсон байсан хэмжээ болно. Тэрхүү хэмжээ Түркойз Хилл Ресурсийн хүүний орлогод төлвөл зохих хэмжээ яг мөн гэдэг нь нотлоход хүндрэлтэй боловч ойролцоо тооцоо болох нь мадаггүй.

бүтэц бий болгосноор 2010–2016 онуудад бараг хагас тэрбум долларын татварын зардал хэмнэн өөрийн компанийн нутаг болох Канадын татварын орлогыг ихээхэн хэмжээгэр дутагдуулж, 88.7 сая ам.долларын татварыг хаа хамаагүй Люксембургд төлжээ.

Уг илтгэлд хариулахдаа, Рио Тинто, Түркойз Хилл Ресурс нь Оюу Толгойн санхүүжилтийн журмыг Канадын Татварын Ерөнхий Газраас гаргасан татварын шийдвэрээр бататган тогтоосон гэжээ. Люксембургийн жишээн дээр тайлбарласнаар, татварын шийдвэр гэж үндэстэн дамнасан корпорацаас санал болгосон шийдлүүдийг холбогдох татварын байгууллага зөвшөөрсөнийг хэлдэг.¹²⁵ Энэ бол Түркойз Хилл Ресурсээс сэдэж хэрэглэсэн Оюу Толгойн санхүүжүүлтийн арга схемийг Канадын татварын байгууллага урьдчилан мэдэж байсан гэсэн үг юм.

Люксембургд Мовель, Нидерландад Оуу Tolgoi Netherlands BV гэх “шуудангийн хайрцаг” охин компаниудыг байгуулснаар тэрхүү орнуудтай ажил төрлийн ямар нэгэн бодит холбоогүй атлаа Түркойз Хилл Ресурс компани нь цаасан дээрх бодит байдлыг зохиож хагас тэрбум долларын татвараас зугтсан байна.

4.3 Оюу Толгойн зүй бус Хөрөнгө оруулалтын гэрээ: Монголд төлөх татварын үүргийг бууруулах нь

Канадын компанийн орлогын татвараас амжилттай зугтсанаас гадна Түркойз Хилл Ресурс компани нь Монголд хүүний гадаад гуйвууллагад төлвөл зохих суутгал татвараас зайлсхийж чадсан байгаа юм. Энэхүү суутгал татварыг хүүний төлбөр буюу ногдол ашгийг дотоодын компаниудаас гадаадад гуйвуулахад авдаг бөгөөд гадаад дахь хүлээн авагч тал нь төлбөр хариуцагч болдог зарчимтай. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын компаниуд идэвхгүй орлогын төлбөр хийх аргаар ашгаа зугтаалгахаас сэргийлж, орлогыг эх орондоо үлдээх зорилготой зохицуулалт юм. Суутгал татварыг уул шугамандаа гадаадад буюу оршин суух орон гэгчид байршилтай хүлээн авагч компани төлөх ёстой байдаг. Өөрөөр хэлвэл, дээр өгүүлсэн Мовель-ээс Оюу Толгой ХХК руу урссан зээлийн хөрөнгийн жишээг авбал, Монголд суутгал татвар төлөх үүрэгтэй тал нь Мовель юм. Монголын компаниас гадаадад төлж буй хүүний гуйвуулгаас МУ-ын татварын байгууллага нь 20%-ийн суутгал авдаг журамтай. Харин Монгол улсаас нилээд хэдэн оронтой байгуулсан ДТХ нь суутгал татварыг 5%-аас 15%¹²⁶ хүртэл бууруулж тогтоосон байдаг байна.

Өмнөх хэсэгт зээлийн санхүүжилтээр Оюу Толгой ХХК-ийн татвар ногдуулах ашгийн хэмжээг бууруулж, Мовель-ийн ашгийг Люксембургд нэмэгдүүлж байгаа тухай өгүүлсэн. Оюу Толгой ХХК-иас төлж буй ихээхэн хэмжээний хүүний төлбөрүүд түүний татвар ногдуулах ашгийг бууруулж, Монголын ашгийн татварын орлогыг багасгаж байгаа юм. Монгол шиг орны хувьд өөрийн нутаг дэвсгэрт зээлээр (ч хамаагүй) явагдаж буй эдийн засгийн идэвхит ажиллагаа (Оюу Толгойн зэс, алтны олборлолт г.м.)-наас татварын орлого бүрдүүлэх нэгэн боломж

125 2018-01-17-нд Рио Тинто, Түркой Хилл Ресурсаас хүлээж авсан SOMO-гийн илтгэлийн талаарх хсанал.

126 PricewaterhouseCoopers, Mongolia: Corporate – Withholding taxes, <http://taxsummaries.pwc.com/ID/Mongolia-Corporate-Withholding-taxes>. Авсан 2017-08-08.

нь хүүний гадаад төлбөрт суутгал татвар ногдуулах зэмсэг юм. Харин, суутгал татварыг бууруулах нөхцөл бүхий ДТХ-үүдийг байгуулснаар гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудаас авах хамгийн чухал татварын энэ эх үүсвэрээсээ өөрөө татгалзаж байгаа болно.

2011 онд Түркоиз Хилл Ресурсээс Оюу Толгойд хөрөнгө оруулалтыг идэвхитэй хийж эхлэх үед суутгал татварыг 10% хүртэл бууруулах нөхцөл бүхий МУ, Нидерландын хооронд байгуулсан ДТХ хүчин төгөлдөр байв. Оюу Толгой ХХК-д олгох зээлийг Нидерландын нутгаар дамжуулан олгосноор энэхүү ДТХ-ийг ашиглан Монголд төлвөл зохих суутгал татварыг бууруулж чадсан юм. Зөвхөн аль нэгэн оронтой байгуулсан ДТХ-ийн нөхцөлийг ашиглах зорилгоор тухайн оронд Оуу Tolgoi Netherlands BV шиг “шуудангийн хайрцаг” компани байгуулж завшихыг “гэрээ арилжих” (treaty shopping) гэдэг юм. Ийнхүү байдлаар гэрээ, хэлэлцээрийг буруу ашиглахыг хязгаарлах зорилгоор Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) -ын хүрээнд татварын баазын элэгдэл ба ашгийн нүүлгэлттэй тэмцэх (Base Erosion and Profit Shifting Project)¹²⁷ нэртэй олон улсын төсөл хэрэгжилтийн шатандаа байна. Гэвч гэрээ арилжихыг зогсоогоогүй нөхцөлд МУ-ын хувьд ийнхүү суутгалын татварыг бууруулах хэлэлцээр байгуулах нь гадаадын компаниудад татвараас зугтах боломжийг олгоод байна гэсэн үг.

Дээр хэлсэнчлэн, МУ-аас бусад орон, түүний дотор Люксембург, Нидерландтай байгуулсан ярвигтай ДТХ-ийг шинжин судалсан ОУВС-ийн 2012 оны илтгэл¹²⁸ гарсаны мөрөөр МУ нь эдгээр хэлэлцээрийг бие даан цуцалсан¹²⁹ бөгөөд энэ нь өөрийн нутгаас гадагшлах санхүүгийн урсгалуудаас татвар авах явдлыг хяналтандаа эргүүлж оруулах алхам байв. Гэвч Монгол дахь хамгийн том хөрөнгө оруулалт бүхий Оюу Толгойн татварын үүргүүдэд энэхүү ДТХ-ийг хүчингүй болгосон нь нөлөөлсөнгүй. Учир нь Рио Тинтогийн МУ-тай байгуулсан 2009 оны Хөрөнгө оруулалтын Гэрээнд гарын үсэг зурах үед хүчин төгөлдөр байсан гэрээ, тохиролцоог “тогворжуулах”-аар заасан байдаг.¹³⁰ Тогтворжуулалтын заалт нь Оюу Толгой ХХК-иас гадаадад гуйвуулах хүүний төлбөрийн суутгал татварын дээд хэмжээг Нидерланд, Люксембургтай хийсэн тухайн үеийн хэлэлцээрт тохирсноор 10% -иас хэтрэхгүй байхаар тогтоожээ. Уг тогтворжилтын улмаас Монгол нь Нидерланд, Люксембургийг зүглэсэн хүүний урсгалд ногдуулсан татвараа өөрчлөх хууль ёсны эрхгүй болсон аж.¹³¹

-
- 127 Business Dictionary, Treaty shopping, <http://www.businessdictionary.com/definition/treaty-shopping.html>.
Авсан 2017-12-04; OECD, Preventing the Granting of Treaty Benefits in Inappropriate Circumstances, Action 6 – 2015 Final Report, 5 Oct 2015, <http://www.oecd.org/tax/preventing-the-granting-of-treaty-benefits-in-inappropriate-circumstances-action-6-2015-final-report-9789264241695-en.htm>. Авсан 2017-12-04
- 128 IMF, Mongolia: Technical Assistance Report – Safeguarding Domestic Revenue – A Mongolian DTA Model, Nov 2012, <https://www.imf.org/external/pubs/ft/scr/2012/cr12306.pdf>. Авсан 2017-08-08.
- 129 Reuters, Special report: In tax case, Mongolian is the mouse that roared, 16 Jul 2013, <https://www.reuters.com/article/us-dutch-mongolia-tax/special-report-in-tax-case-mongolia-is-the-mouse-that-roared-idUSBRE96F0B620130716>.
Авсан 2017-08-16.
- 130 Reuters, Special report: In tax case, Mongolian is the mouse that roared, 16 Jul 2013, <http://www.reuters.com/article/us-dutch-mongolia-tax-idUSBRE96F0B620130716>. 2017-08-08.
- 131 The Government of Mongolia, Ivanhoe Mines Mongolia Inc LLC, Ivanhoe Mines Ltd, and Rio Tinto International Holdings Limited, Investment Agreement, 6 Oct 2009, http://www.turquoisehill.com/ii/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF.
Авсан 2017-08-08.

Оюу Толгой ХХК-ийг голчлон зээлээр санхүүжүүлж байгааг харгалзвал түүний хүүнд төлж байгаа зардлын хэмжээгээр ашиг нь буурч, МУ энэ уурхайгаас авах орлогын татвар үлэмж багасна. Ийм тохиолдолд МУ-ын хувьд хамгийн чухал нь Оюу Толгойгоос төлөх хүүний төлбөрийн суутгал татвар болж таарч байгаа юм. Гэвч МУ-ын Засгийн газар ОТХОГ-нд гарын үсэг зурснаараа энэхүү орлогын эх үүсвэрийг 20%-аас 10% болгон хагасалсан.

Рио Тинто, Түркойз Хилл РесурсХХК нь эл илтгэлийн талаар өгсөн саналдаа хүүний төлбөрийн суутгал татварыг 20%-иас 10% хүртэл бууруулах заалтыг Монгол улсаас Канадтай байгуулсан ДТХ-ээрт адил тусган баталгаажуулсныг дурьдсан байгаа.¹³² Иймээс санхүүжилтийг Люксембургаас бус, харин Канадаас авах нь Оюу Толгойгоос төлөх хүүний суутгал татварыг мөн л хэмжээгээр бууруулахад хүрэх юм. Монгол шиг гадаадын шууд хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай хөгжиж буй орон болон уг хөрөнгө оруулалтыг хийдэг Канад шиг хөгжингүй орны хооронд байгуулсан ДТХ-т орлогын татварыг бууруулах заалтыг тусгаснаар хөгжиж буй орны татвар татах эрх хумигддаг нь амьдралын үнэн¹³³ бөгөөд энэхүү тэгш бус харилцааны улмаас Монгол шиг орны хувьд татвар бууруулсан заалттай гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах нь ихээхэн уршигтай явдал болдог. Иймэрхүү гэрээ хэлэлцээрийг өөртөө бүртгэлтэй компаниудад хэт давуу тал олгодог Люксембург, мөн гуравдах орнуудаас гаралтай санхүүгийн урсгалын суваг болж өгдөг Нидерланд зэрэг эл илтгэлд яригдаж буй татвараас зайлсхийх үйлдлийг өөгшүүлэн дэмждэг улсуудтай байгуулах нь бүр ч уршигтай болох нь дамжиггүй.

2013 онд МУ-ын ЗГ-аас ОТХОГ-ний нөхцөлийг хэлэлцэн хянах оролдлогыг хийхэд Рио Тинто ЗГ-ын хооронд үүссэн маргаан нь Оюу Толгой дахь хөрөнгө оруулалтыг хойшлуулав. Оюу Tolgoi Netherlands-ын 2015 оны тайлан илтгэлд мэдээлснээр Рио Тинто, ЗГ-ын яриа хэлэлцээний явцад Оюу Толгой ХХК-иас гадаадад төлөх хүүнд ногдуулах суутгал татварыг 10%-аас 6.6% хүртэл бууруулах шийдвэрийг МУ-ын ЗГ-аар гаргуулж чадлаа гэсэн байдаг. Үүгээр зогсохгүй, тэрхүү буурсан хэмжээг бүр өмнөх таван жилийн хүүний татварт хамааруулах болсон аж. Ийнхүү байдлаар Монголд тэр үед төлөгдөх ёстой байсан Оюу Tolgoi Netherlands BV-ын суутгал татварыг 27 сая ам.доллараар бууруулжээ.¹³⁴ ОТХОГ-нд ийм өөрчлөлт¹³⁵ оруулсан нь өөрийн 34% өмчлөлтэй холбоотой татварын үүргийг МУ-ын ЗГ өөрөө хариуцна гэх байдлаар Оюу Толгой ХХК-ийн авсан зээлийн хүүний төлбөрийн суутгал татварын мөн 34%-ийг төлөхөөр болсонтой холбоотой байна.¹³⁶

132 Түркойз Хилл Ресурс, Рио Тинтогоос уг илтгэлийн хариуд илгээсэн e-мэйл (хүлээж авсан 2018-01-17)

133 Tax Justice Network, Source and Residence Taxation, 15 Sep 2005, <http://www.taxjustice.net/cms/upload/pdf/Sourceresidence.pdf>. Авсан 2017-12-15.

134 Оюу Tolgoi Netherlands B.V., 2015 оны тайлан илтгэл. Авсан 2017-09-06.

135 Энэхүү өөрчлөлтийг ОТХОГ болон холбогдох Хувьцаа Эзэмшигчдийн хоорондын (гол төлөв Рио Тинто, МУ-ын ЗГ-т хамаарсан) гэрээнд тус тус хэсэгчлэн дурдсан байдаг. Эдгээр гэрээг дараах хаяг, холбоосоор олно: Erdenes Mongolia LLC, Ivanhoe Oyu Tolgoi (BVI) Ltd, Oyu Tolgoi Netherlands BV, Oyu Tolgoi LLC, Amended and Restated Shareholders Agreement, article 11.3e, 8 Jun 2011, <http://www.turquoisehill.com/i/pdf/>. OT-ARSHA-ENG-2011-06-08-Executed.pdf. Авсан 2017-09-08; The Government of Mongolia, Ivanhoe Mines Mongolia Inc LLC, Ivanhoe Mines Ltd, and Rio Tinto International Holdings Limited, Investment Agreement, 6 Oct 2009, http://www.turquoisehill.com/i/pdf/Oyu_Tolgoi_IA_ENG.PDF. Авсан 2017-08-08.

136 Oyu Tolgoi Netherlands BV, 2015 annual report, 22 Dec 2016, www.kvk.nl. Авсан 2017-09-06.

Суутгал татварыг хариуцах эзэн нь төлбөр хийгч биш, харин хүлээн авах гадаад тал байдаг тул энэхүү тохиролцоо нь логикийн алдаатай болж таарч байгаа юм. Татварын суутгал хийхийн зорилго нь татвар ногдуулах орлогын суурийг гадаад шилжүүлгийн нэрийн дор бууруулахаас хамгаалах явдал мөн тул хүүний төлбөрийг хүлээн авагч Мовель болон Оюу Tolgoi Netherlands нар энэ орлогосоо татвар төлөх учиртай ба тэдний төлөх татварыг Эрдэнэс Оюу Толгой ХХК нь ЗГ-т хамаатай болох үндэслэлээр бууруулах нь утгагүй явдал юм. Монголын ЗГ эдгээр компанид хамаагүй, харин хүү төлөгч Оюу Толгой ХХК-ийн 34%-ийг өмчилдөг тул суутгал татвар төлөх этгээд огтхон ч биш. Цаашилбал, суутгал татварын хэмжээг зөвхөн 2015 оны хэлэлцээ дууссаны дараа бууруулсаныг харвал энэ нь Монгол улсын татварын хуулийн дагуу хийсэн тохируулга биш, гагцхүү хэлэлцэж наймалцсаны үр дагавар мөн гэх хардалтыг төрүүлнэ. Ямар ч бай, Гэрээний энэ өөрчлөлт нь Түркойз Хилл Ресурс (болон Рио Тинто)-ийн татварын зардлыг цааш бууруулж өгсөн аж.

Оюу Толгойн өмчлөгч компаниуд болон МУ-ын ЗГ-ын хоорондох Хөрөнгө оруулалтын Гэрээний агуулга, түүнийг байгуулан хэрэгжүүлэх үйл явц зүй бус шинж чанартай болох тухай дүгнэлт эл илтгэлээс урган гарч байгаа юм. Суутгал татварыг удаа дараа үлэмж багасгасан нь МУ-ын уурхайн үйл ажиллагаанаас олох орлогыг танаж, Оюу Толгойгоос зээлийнхээ хүүд төлж буй зардал уурхайн ашигт ажиллагааг бууруулан ногдол ашиг хүртэх боломжийг нь үгүйсгэж байна. Энэхүү Хөрөнгө оруулалтын Гэрээг байгуулснаар суутгал татвараар авбал зохих байсан орлогын алдагдлыг дараах хүснэгтэд шинжиж үзэв.

Хүснэгт 5 ОТХОГ-ний нөхцөлөөр Монголын суутгал татварын орлогын алдагдал х US\$1,000

	2011	2012	2013	2014	2015	Дүн
Нийт хүү	120,438	287,388	407,908	466,276	450,052	1,732,062
Хэлэлцээрийн нөхцөлөөр төлөх суутгал татвар	7,949	18,968	26,922	30,774	29,704	114,316
МУ-ын хуулийн дагуу төлөх суутгал татвар	24,088	57,478	81,582	93,255	90,011	346,412
Монголыг татварын орлогын алдагдал	16,139	38,510	54,660	62,481	60,307	232,096

2011–2015 онуудад Оюу Толгой ХХК нь Мовель болон Оюу Tolgoi Netherlands компаниудаас олгосон зээлийн хүүд 1.7 тэрбум ам.доллар төлсөн байна. ОТХОГ-ний нөхцөлийн дагуу хүүний төлбөрт 6.6% суутгал татвар бодогдож Монголын талд 114 сая ам.доллар төлөгдөхөөр байна. Хэрэв МУ-ын ЗГ өөрийн дотоодын хуулиар тогтсон 20%-ийн хэмжээгээр суутгал татварыг авч байхаар тохирч чадсан бол Оюу Толгойгоос авах татварын орлого гурав дахин буюу 230 ам.доллараар илүү байх байж.

Харьцуулах зорилгоор 2016 оны Монголын төсвийн нийт зардлыг авч үзвэл \$1.61 тэрбум байсан¹³⁷ ба сүүлийн үеийн тоо баримтаар боловсролд зарцуулах төсвийн зардал нь нийт

137 World Bank, Data: General government final consumption expenditure, <https://data.worldbank.org/>. Авсан 2017-08-08.

зардлын ойролцоогоор 5% буюу 80 сая ам.доллар болж,¹³⁸ мөн эрүүл мэндэд бас л энэ зэргийн санхүүжилт гарсан аж.¹³⁹ Энэ хөрөнгөөр эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг Монголын 3 сая хүн амд хүргэдгийг харвал Монголын Засгийн газар нэг иргэндээ жилд ойролцоогоор 27 ам.доллар зарцуулж байгаа юм.¹⁴⁰ Гэтэл Нидерланд нь нэг хүний эрүүл мэнд, боловсролд 5,700 ам.доллар болон 2,500 ам.доллар тус тус зарцуулдаг байна.¹⁴¹ Оюу Толгойн доромжлолт ОТХОГ-ний уршгаар сүүлийн гурван жилийн турш төсөвт орвол зохих татварын орлогоос жил бүр \$60 сая ам.доллар алдахын оронд татвараа улсынхаа хууль тогтоомжийн дагуу татсан бол МУ нь боловсрол эсвэл эрүүл мэндийн хөрөнгө оруулалтаа бараг нугалж чадах байжээ.

Шигтгээ 3 Оюу Толгойн 2 дахь шат: Олон улсын санхүүгийн байгууллагууд татвараас зайлсхийх үйлдэл, байгаль орчин, нийгмийн зөрчлүүдийг (санамсаргүйгээр) өөгшүүлэх нь

Рио Тинто болон МУ-ын Засгийн газрын хооронд Оюу Толгойн орлогыг хуваарилах талаар үүссэн маргаан 2015 онд шийдвэрлэгдсэний дараа Оюу Толгойн 2 дахь шат эхлэх боломжтой болж, Рио Тинто ч 4.4 тэрбум ам.доллар босгож чадсан аж. Оюу Толгойн 2 дахь шатны үйл ажиллагааны санхүүжилтийг банкууд¹⁴², экспортын зээлийн даатгалын компаниуд, дотоодын болон олон улсын санхүүгийн байгууллагууд гаргаж байгаа юм. Санхүүгийн энэ үйл ажиллагаанд оролцогсодын дунд Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ), Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК) болон Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг (ОТХОБА буюу MIGA), Нидерландын хөгжлийн банк (ФМО), Канадын экспортын хөгжлийн агентлаг, Австралийн экспортын санхүү, даатгалын корпорац, АНУ-ын Экспорт-импортын банк зэргийг дурьдвал зохино.¹⁴³ Оюу Толгойн санхүүгийн тогтолцоо өнөө хүртэл татвараас зайлсхийх чиглэлд ажиллаж ирснийг санавал дээрх байгууллагууд холбогдох улс, бүс нутгийн татвар төлөгчдөөс гаргуулан нийлүүлж буй үлэмж хэмжээний нийтийн хөрөнгө мөнгө нь мөнөөх л санхүүгийн тогтолцоогоор дамжиж, улмаар татвараас зайлсхийх үйлдэл үргэлжлэх үү? гэсэн асуулт гарч ирнэ.

138 World Bank, Data: Government expenditure on education, <https://data.worldbank.org/>. Авсан 2017-08-08.

139 World Health Organization, Mongolia <http://www.who.int/countries/mng/en/>. Авсан 2017-12-06.

140 Central Intelligence Agency, The World Factbook: Mongolia, <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/geos/mg.html>. Авсан 2017-12-06.

141 Rijksoverheid, Overzicht inkomsten en uitgaven Rijksoverheid 2018, <https://www.rijksoverheid.nl/onderwerpen/prinsjesdag/inkomsten-en-uitgaven/overzicht-inkomsten-en-uitgaven-rijksoverheid-2018> 2 January 2018. Авсан 2018-01-02.
Worldometers, Netherlands Populations, <http://www.worldometers.info/world-population/netherlands-population/>. Авсан 2017-12-06.

142 These include Australia & New Zealand Banking Group, Bank of Tokyo-Mitsubishi, BNP Paribas, CIBC, Credit Agricole, HSBC, ING Bank, Intesa Sanpaolo, KfW IPEX-Bank, National Australia Bank, Natixis, Societe Generale, Standard Chartered Bank, Sumitomo Mitsui Banking Corp. Source: Reuters Eikon, Oyu Tolgoi debt structure.

143 Source: Reuters Eikon, Oyu Tolgoi debt structure.

☛ **Шигтгээ 3 Оюу Толгойн 2 дахь шат: Олон улсын санхүүгийн байгууллагууд татвараас зайлсхийх үйлдэл, байгаль орчин, нийгмийн зөрчлүүдийг (санамсаргүйгээр) өөгшүүлэх нь**

Эхний шат нь ил уурхай бол 2 дахь шат нь зэс, алтны хүдрийг тэсэлгээ явуулах аргаар газрын гүнээс олборлох далд уурхай юм. Уурхайн байршиж буй говь цөлийн шинжтэй газар нь усны хомсхон нөөцөөс хамааралтайгаар аж төрдөг малчдын нутаг юм. 2 дахь шат нь өмнөх шатнаас эрс өөр олборлолтын төрөл бөгөөд тэсэлгээний улмаас үүсэх газрын чичирхийлэл, газрын гадаргууны тогтворгүй байдал нь ноцтой эрсдэл бий болгохын зэрэгцээ уурхайн усны хэрэглээ, уур амьсгалын хувиралт болон малын нүүдэллэх хөдөлгөөн хоригдох зэрэг нь хавсарч нутгийн усны нөөцийг улам хомсдуулах магадлалтай байна. 2 дахь шатны Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг тодотгон шинэчлэх шаардлага, үндэслэлийг Оюу Толгойн өөрийнх нь нийтэд нээлттэй 2015 оны Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нотлон харуулсан ч тэд 2012 онд хийсэн БОННУ нь уурхайн хоёр шатны аль алиныг хамруулсан хэмээн зүтгэсээр байна.¹⁴⁴

Байгаль орчны болон нийгмийн эрх зөрчигдөх, Оюу Толгойн 2 дахь шатны санхүүжилтийн явцад татвараас зайлсхийх үйлдэл гарах зэрэг эрсдлүүд нь дээрх нийтийн санхүүгийн байгууллагуудын хувьд нухацтайгаар хандан харгалзах асуудлууд юм. Тэд Оюу Толгойд хөрөнгө оруулснаараа Рио Тинтогийн зүй бус ажиллагаатай холбогдох магадлал бий. СОМО-гоос 2018 оны сүүлд хэвлэн гаргах нийтлэлд эдгээр байгууллага болон Оюу Толгойн хоорондын харилцан холбоог авч хэлэлцэнэ.

Энэ бүхэн нь боловсрол, эрүүл мэнд, бусад олон салбарт гаргаж буй дутмагхан төсөв болон ОУВС-тай тохирсон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд бүсээ чангалах арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгааг санавал үнэхээр харамсалтай явдал юм.¹⁴⁵

144 CEE Bankwatch Network, Oyu Tolgoi Phase 2: Plans, Issues and Risks, 11 February 2016, <https://bankwatch.org/publication/oyu-tolgoi-phase-2-plans-issues-and-risks>. Авсан 2016-12-12.

145 Reuters, Mongolia agrees \$5.5 billion economic bailout plan with IMF, others, 19 Feb 2017, <https://www.reuters.com/article/us-mongolia-imf/mongolia-agrees-5-5-billion-economic-bailout-plan-with-imf-others-idUSKBN15Y02S>. Авсан 2017-12-06.

4.4 Нийт татварын алдагдал

Өмнөх бүлэгт Рио Тинто болон Түркоиз Хилл Ресурс нь Монгол, Канадад төлөх татвараа бууруулж дутуу төлсөний багцаалсан тооцоог хүргэсэн бөгөөд уг тооцоог төсөөлсөн нөхцөл байдал болон тэдний хэрэглэж ирсэн татвараас зугтах арга схемьг харьцуулах үндсэн дээр хийсэн тул эдгээр тоо нь татварын орлогын алдагдлын бодитой тоон мэдээ биш, харин төсөөлөн таамагласан тоо гэж ойлгох ёстой.

Оюу Толгойн ашиг орлогоос төлөх ёстой татварыг нэлээд хэмжээгээр бууруулах боломжийг олгосон Рио Тинтогийн хэрэглэж буй татвар бууруулалт болон татвараас зайлсхийлтийн схемьн үндсэн аргыг дараах байдлаар нэгтгэн харуулж болно. Үүнд:

- ▣ Монгол улсаас Нидерланд, Люксембургтэй байгуулж, дараа нь татвараас зайлсхийлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор цуцалсан татварын хэлэлцээрийн таатай нөхцлүүдийг Оюу Толгойн орлогоос татах суутгал татварыг 10% хүртэл бууруулахад ашигласан;
- ▣ Рио Тинтотой үүссэн маргааны мөрөөр Монголын Засгийн газраас хийсэн буулт хэмээн ойлгогдохуйц тохиролцоонд үндэслэн 2015 онд суутгал татварыг доош 6.6% хүртэл бууруулаад буцаан хэрэглэсэн;
- ▣ Люксембургийн засгийн газартай тохиролцсон байж болзошгүй маш доогуур буюу 4.19%-иар тогтоосон орлогын татварыг тус улсад шуудангийн хайрцаг төдий бүртгэлтэй компанийг ашиглах замаар сүүлийн 7 жил завшиж ирсэн аж.

Монголын хувьд Засгийн газраас олгосон татварын давуу нөхцлийг ашигласны улмаас нийт 232 сая ам.долларын суутгал татварын алдагдал гарсан бол Канадын хувьд санхүүгийн схем хэрэглэсний улмаас 470 сая ам.долларын компанийн орлогын татварын алдагдал гарсныг нийтэд нээлттэй мэдээллээс харж болно. Эдгээр тоо нь зээлийг татварын диваажинд байрших охин компаниар дамжуулан санхүүжилтээ хийх аргыг ашиглаж хүүний суутгал татвар болон компанийн орлогын татвар гэх хоёр өөр төрлийн татварыг бууруулан дутуу төлсөнөөр бий болсон татварын орлогын алдагдал гэдгийг дахин тэмдэглэж байна. Хоорондоо ялгаатай ч энэ татваруудыг нэгэнт Оюу Толгойн ашиг орлогод ногдуулсан болохоор харилцан хамааралтай болно. Учир нь Монгол улс Оюу Толгой ХХК-ийн төлж буй хүүгээс өнөөгийн 6.6%-ийн суутгал татварын оронд 20%-ийн суутгал татвар авсансан бол энэ нь Люксембург дэх Мовель компанийн орлогыг бууруулах (өнөөгийн байдалд), мөн Канад дахь Түркоиз Хилл Ресурс компанийн орлогыг (Канадын татвараас зайлсхийгээгүй таамаглал бүхий нөхцөлд) буурахад хүргэх байв. Суутгал татварыг өсгөх нь Монголын хувьд татварын орлогын алдагдлыг багасгах бол Канадын хувьд нэхэн олж болохуйц татварын орлогыг нь мөн бууруулах үйлчлэлтэй юм.

Иймээс дутуу төлсөн татвар болох 232 сая болон 470 сая ам.долларын нийлбэр дүн буюу 700 сая ам. доллар нь Канадын бодит татварын алдагдал, мөн нэхэн олж болохуйц орлогыг тодорхой хэмжээгээр хэтрүүлэн харуулж байгаа юм. Энэ тоо арай бага байх ёстой боловч түүнийг Түркоиз Хилл Ресурс болон охин компаниудынх нь татвар төлөлтийн тайлан мэдээлэл хүртээмжгүй байгаагийн улмаас нарийн тооцоолж гаргах боломжгүй байна.

5 Нидерланд дахь “шуудангийн хайрцаг” компанийг дөрөөлсөн гэрээний урвуулан ашиглалт

Оюу Толгойн уурхайн лицензийг эзэмшигч Оюу Толгой ХХК-ийг Түркоиз Хилл Ресурс компанийн Нидерланд дахь охин компани Оуу Tolgoi Netherlands BV өмчилдөг ба түүнийг мөн тэндэхийн Turquoise Hill Netherlands Coöperatief U.A. өмчилнө.¹⁴⁶ Энэ хоёр компани нь хоёул Intertrust нэртэй траст компанийн Prins Bernhardplein 200 гэх хаягаар бүртгэлтэй. Дээрх траст компанийн менежментэд байдаг тэр хоёр компани нь өөрийн хамгийн сүүлийн жилийн тайландаа¹⁴⁷ ажилтан огт үгүй гэсэн нь тухайн компаниуд зөвхөн цаасан дээр бүртгэгдсэн, Нидерландад ямар ч бодит эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаггүй гэсэн үг.

Түркоиз Хилл Ресурс ба цаана нь буй Рио Тинто компани нь энэхүү хоёр охин компанийг Нидерландад бүртгүүлсэн нь Нидерландын бусад оронтой байгуулах гэрээ хэлэлцээрт зөвхөн өөрийн дотоодын компаниудад зориулан тусгасан санхүүгийн хөнгөлөлт ба\буюу хөрөнгө оруулалтын хамгааллыг хүртэх зорилготой байж. Энэхүү дүгнэлтийн талаар Түркоиз Хилл Ресурс, Рио Тинто хариулахдаа Монгол-Нидерландын хоорондох Хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээрээр олгогдсон хамгаалал нь охин компаниудаа Нидерландад бүртгүүлэхийн нэгэн үндэслэл болсон гэв. Тухайн тэр үед Канадтай ийм хэлэлцээр байгуулаагүй байсан аж. Бодит чанаргүй, дамжуулан өнгөрөөх үүрэг бүхий этгээдийг байгуулж гэрээ хэлэлцээрийн таатай нөхцлүүдээс завших нь “гэрээ арилжих”-ын шинж тэмдэг юм. Гэрээ арилжих гэдэг нь ямар нэг гуравдагч орны компани хоёр өөр улс хоорондын байгуулсан гэрээний нөхцөлөөр зөвхөн ашиг хонжоо олох зорилгоор тэрхүү хоёр улсын аль аятайхан нөхцөлт нэгний нутагт дамжуулагч төдий компани буюу өөр хуулийн этгээдийг байгуулахыг хэлдэг байна.¹⁴⁸

Өмнө тайлбарласанаар Оуу Tolgoi Netherlands BV компанийг Люксембургээс Монголд олгож буй зээлийн суваг болгож ашиглан татвараас зайлхийдэг, мөн ирээдүйд Оюу Толгойг худалдах болзошгүй тохиолдолд хөрөнгийн орлогын татвараас зугтахад ашиглах магадлалтай. Turquoise Hill Netherlands Cooperatief U.A. компанийг Оуу Tolgoi Netherlands BV компанийн авч буй ногдол ашгийн татвараас зугтах зорилгоор ашиглаж байна. Нөгөөтэйгүүр, Нидерландын шуудангийн хайрцаг компанийн бүтцийг зөвхөн татвараас зугтах бус бас хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилгоор ашиглаж байх магадлалтай. 1996 оны зургадугаар сард МУ, Нидерландын хоорондын Хоёр талын харилцан хөрөнгө оруулалтын гэрээ (ХТХХОГ) байгуулагдаж нэгээс нөгөөхөд хөрөнгө оруулсан компаниудад маш өндөр хэмжээний хамгаалалт, баталгаа тусгасан байдаг. Жишээлбэл энэ ХТХХОГ-т хөрөнгө оруулалтыг хүлээн авч буй тал нь хөрөнгө оруулалтын

146 Orbis database, Bureau van Dijk. Авсан 2017-12-04.

147 Оуу Tolgoi Netherlands BV, 2015 annual report, 22 Dec 2016, www.kvk.nl. Авсан 2017-09-06; Turquoise Hill Netherlands Coöperatief U.A., 2015 Annual Report, 22 Dec 2016, www.kvk.nl. Авсан 2017-09-06.

148 V. Krishna, Treaty Shopping and the Concept of Beneficial Ownership in Double Tax Treaties, Aug 2009, http://commonlaw.uottawa.ca/15/index.php?option=com_docman&task=doc_download&gid=2805. 2017-10-15.

хэмжээг бууруулахаас татгалзана¹⁴⁹, хөрөнгө оруулалттай холбоотой аливаа төлбөр тооцоо (ногдол ашиг, хүүний төлбөр)-г саатуулах, хойшлуулахаас татгалзана¹⁵⁰, мөн түүнчлэн хөрөнгө оруулагч компани нь хөрөнгө оруулттай холбоотой маргаант асуудлаар Хөрөнгө оруулалтын маргаан таслах Олон улсын төв \International Centre for Settlement of Investment Disputes\–д гомдол гаргаж болно гэх хатуухан нөхцөл тохирсон байдаг.¹⁵¹

Туркойз Хилл Ресурс–ын охин компани Мовель – Оюу Толгойн жинхэнэ хөрөнгө оруулагч гээгч– нь Люксембургэд бүртгэлтэй ба тэр МУ–тай байгуулсан ХТХХОГ үгүй.¹⁵² Тийм учраас Нидерланд дахь охин компаниар дамжуулан хөрөнгө оруулах замаар МУ, Нидерландын уг хэлэлцээрт заасан хөрөнгө оруулалтын хамгаалалтыг зүй бусаар ашиглах боломж олж байна. МУ–ын ЗГ нь Оюу Толгойн баялгийн тэгш бус хуваарилалтын талаарх төгсгөлгүй болон үр дүнгүй маргааныг зогсоож, Оюу Толгойг өөрийн мэдэлд авахаар шийдвэл Хөрөнгө оруулалтын маргаан таслах Олон улсын төвд очиж Хэлэлцээр зөрчсөн тухайгаа тайлбарлан зогсох болно. Ийм мэт хөрөнгө оруулалтын маргаан нь бага орлоготой орнуудын ихээхэн эрэлт хэрэгцээтэй төсөв санхүүг хорогдуулж, иргэдийнхээ эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах чадварыг нь сулруудаг.¹⁵³ Ийнхүү энэ цаасан дээрх төдий хиймэл өмчлөлийн бүтэц нь Рио Тинтогийн хөрөнгө оруулалтыг хамгаалж, харин уурхайгаас авах орлогоо нэмэгдүүлэхийн тулд арга хэмжээ авах аливаа боломжийг МУ–ын ЗГ–ын хувьд хааж хязгаарлана.

149 Government of the Netherlands and the Government of Mongolia, Agreement on encouragement and Reciprocal Protection of Investments between the Kingdom of the Netherlands and Mongolia, article 5, <http://investmentpolicyhub.unctad.org/Download/TreatyFile/2020>, 2017–10–15.

150 Government of the Netherlands and the Government of Mongolia, Agreement on encouragement and Reciprocal Protection of Investments between the Kingdom of the Netherlands and Mongolia, article 4, <http://investmentpolicyhub.unctad.org/Download/TreatyFile/2020>. Авсан 2017–10–15.

151 Government of the Netherlands and the Government of Mongolia, Agreement on encouragement and Reciprocal Protection of Investments between the Kingdom of the Netherlands and Mongolia, article 8, <http://investmentpolicyhub.unctad.org/Download/TreatyFile/2020>. Авсан 2017–10–15.

152 Investment Policy Hub, Mongolia: Bilateral Investment Treaties (BITs), <http://investmentpolicyhub.unctad.org/IIA/CountryBits/139>. Авсан 2017–10–15.

153 Both Ends, Milieudefensie, SOMO and TNI, 50 jaar ISDS, 13 Jan 2018, <https://www.somo.nl/nl/50-jaar-isds-eenmondiaal-machtmiddel-voor-multinationals/>. Авсан 2018–01–20.

6 Дүгнэлт

Оюу Толгойн зэс, алтны уурхайн төсөл нь Монголд өнөө цагт хийгдэж буй хамгийн том хөрөнгө оруулалт юм. Төслийн гараанд Оюу Толгой ХХК-ийн ерөнхийлөгч уурхайн бүтээгдээхүүний тэн хагаасаас илүү хэсэг Монголын төрд очиж, төслийн үр шимийг “нийт монголчууд болон тэдний хойч үе хүртэх” тухай сүр жавхаатайгаар амласан аж.¹⁵⁴ Гэвч Рио Тинто нь яриа хэлэлцээнд хүч түрсэн байдлаас хандан Монголын Засгийн газраас ихээхэн хаялгатай давуу эрхийг нэхэн авч, Оюу Толгойн уурхайгаас олох орлогоо нэмэгдүүлж, харин зардлаа татвараас зайлсхийх олон улсын арга бүтцүүдийг ашиглан багасгаж ирсэн аж. Уурхайн баялаг өдгөө хүртэл Рио Тинто болон түүний хамтрагч хөрөнгө оруулагчдын л авдар савыг дүүргэсээр байна гэлтэй.

Оюу Толгойн уурхайн удирдлага, санхүүгийн тогтолцоо нь яг энэ үйл ажиллагааг тэтгэн дэмжихээр зохион байгуулагджээ. Уурхайн өмчлөл нэг талаас Монголын төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК (34%), нөгөө талаас Рио Тинтогийн олонх хувьцаат өмчлөл бүхий Түркойз Хилл Ресурс компани (66%)–д байдаг бөгөөд Түркойз Хилл Ресурс нь уурхайн санхүүжилтийг татвараас зайлсхийх арга сувгаар дамжсан зээлээр хангадаг аж. Эрдэнэс компани нь өөрийн 34%-ийг санхүүжүүлэх хөрөнгийг Түркойз Хилл Ресурсээс зээлсэн ба Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд Монголын тал энэ зээлээ бүрэн эргэн төлсөний дараа л уурхайн орлогоос өөртөө ногдох хэсгийг авна гэж заажээ. Гэтэл авах тухай заалт нь өнөө хүртэл хэрэгжилтээ олсонгүй. Зээлийн үлдэгдлийн балансыг харвал 2017 оны 6-р сарын 1-ний өдөр буюу Оюу Толгойн уурхай ажиллаж эхэлснээс 4 жил өнгөрсөн байдлаар Монголын тал 1.1 тэрбум ам.долларын өртэй үлдсээр байна.

Монголын Засгийн газраас уурхайн орлогоос хүртэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх талаар Оюу Толгой төсөлтэй тохирохоор удаа дараалан хийсэн оролдлого нь амжилтанд төдийлөн хүрсэнгүй. Тухайлбал, Монголын ЗГ олборлох салбараас авах орлогоо өсгөхийн тулд гэнэтийн ашгийн татварыг 2006 онд нэвтрүүлсэн ч Оюу Толгойн хөрөнгө оруулагчдын шахалтанд орсноор уг татвараа цуцлахад хүрчээ. Энэхүү байдал Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг эргэн хянахыг 2012 онд оролдоход дахин давтагдсан аж. ЗГ нь 1,700 хүнийг ажлаас халж, Оюу Толгойн өргөтгөлийг хойшлуулчихсан Рио Тинтогийн шахалтанд дарагдан дийлдэж төлвөл зохих татварын зөвхөн талыг төлөх нөхцлийг 2015 онд хүлээн зөвшөөрснөөр уг маргаан эцэс болжээ.

2013 онд Монголын ЗГ ОУВС-аас гаргасан илтгэлийн мөрөөр арга хэмжээ авч Нидерланд, Люксембург улстай байгуулсан татварын хэлэлцээрүүдээ илтгэлд зөвлөсөн олон жилийн чирэгдэлтэй шинэчлэл хийхийн оронд бүр мөсөн цуцалсан аж. Энэ нь Рио Тинтогийн татвараас зайлсхийх явдлыг шийдвэрлэх санаатай байсан боловч Рио Тинтогийн төлөх татвар ОТ-н Хөрөнгө оруулалтын гэрээгээр “тогтворжсон” тул компанийн татвар төлөх үүрэг нэмэгдэхгүй хэмээн Рио Тинтогийн төлөөлөгч мэдэгджээ. Татварыг 2009 оны түвшинд ийнхүү тогтворжуулах буюу царцаахыг зөвшөөрснөөр Монгол Улсын ЗГ нь уул шугамандаа татвараа улсынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тогтоох бүрэн эрхээсээ татгалзсан гэлтэй.

154 Оюу Толгой: Нийт монголчууд хүртэнэ хэмээн ОТ-йн Гүйцэтгэх захирал хэлэв, <http://ot.mn/s-643/>. Авсан 2018-01-09.

Рио Тинто нь дэлхийн хамгийн том татварын диваажин болох Нидерланд, Люксембургтэй хамаа бүхий татвараас зайлсхийх бүтцийг ашиглав.¹⁵⁵ Зургаан (6) тэрбум гаран ам.долларыг Люксембургд шуудангийн хайрцаг төдий бүртгэлтэй компанид шилжүүлсэн бөгөөд энэ нь Нидерландад бас л шуудангийн хайрцаг төдий бүртгэлтэй компаниар дамжин шууд болон шууд бус зээлийн хэлбэрээр Оюу Толгойг санхүүжүүлжээ. “Шуудангийн хайрцаг” гэгч компаниудыг татварын хэлэлцээрт тусгасан аливаа давуу тал (тухайлбал Нидерланд, Люксембургээс үзүүлж буй хөнгөлөлтүүд)-г зүй бусаар хүртэхийн тулд ашиглахыг гэрээний урвуулан ашиглалт гэж үздэг.

Европын Холбооны Зөвлөлөөс саяхан “хамтран ажиллахаас татгалзсан татвар тогтоох бүрэн эрхт этгээд” (non-cooperative tax jurisdictions) буюу татварын диваажингуудын жагсаалтыг гаргасан бөгөөд түүнд Нидерланд, Люксембург нар нь харагдахгүй байтал Монгол улс багтачихжээ.¹⁵⁶ Монгол нь татварын диваажин хэмээн нэрлэгдэхгүй ч ЕХ-той татварын асуудлаар хамтран ажилладаггүй учраас энэ жагсаалтад орсон аж. Уг жагсаалт нь ЕХ-ноос өөрийн гишүүн орнууд болон гуравдах орнуудад ялгаатай хэм хэмжээ хэрэглэдгийг харуулж байгаа юм. ЕХ-ноос татвараас зайлсхийлттэй тэмцэхээр авч буй арга хэмжээ тэмдэглүүштэй боловч энэ ажилд нь өөрийн хэд хэдэн гишүүн, түүний дотор Нидерланд, Люксембург, Ирланд зэрэг нь дэлхийг толгойлсон татварын диваажин болж хувирсан асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа нь саад болсоор байна.¹⁵⁷ Рио Тинто нь Нидерланд, Люксембургийн аль алинд татварын давуу нөхцөл олж авсан ба энэ нь Рио Тинтогийн татвараас зайлсхийх үйлдлийг энэ хоёр орны татварын албаны хувьд угтаа хүлээн зөвшөөрөгдөхүйц болгож байгаа нь магадлалтай. Ийм учраас ЕХ-ны татварын диваажигуудын жагсаалтанд Монгол орчихсон, харин Монголыг зовоосон татвар зувчуулах явдлыг өөгшүүлсэн ЕХ-ны гишүүн орнууд тэр жагсаалтнаас гадуур үлдчихсэн утгагүй байдал бий болжээ.

Нидерландын засаг төр өөрийн оронд охин компанийг хялбархан үүсгэн байгуулах боломж олгодгоороо Рио Тинтод гэрээ болон тус улс дахь санхүүгийн таатай нөхцлийг урвуулан ашиглахыг зөвшөөрчээ. Энэхүү охин компани нь Нидерландад бүртгэлтэй аливаа хуулийн этгээд эдийн засгийн бодитой чанар агуулсан байхыг баталгаажуулахаар тогтоосон “бодитой агуулгын болзол” хэмээх шаардлагыг хангах ёстой юм. Гэтэл ажилтангүй атлаа тэрбумаар тооцох зээлийн хөрөнгийг орж гарах чиглэлд урсгасан компани хэд хэдэн жилийн турш энэ үйл ажиллагаагаа явуулж ирсэн нь дээрх болзол үйлчилдгүйг харуулна. Оюу Толгойн төсөлд хамаарах Нидерландын хоёр охин компани ажилтангүйгээ тайлагнан мэдээлдэг бөгөөд аж ахуйн аливаа үйл ажиллагаа эрхлэдэггүй байдалтай юм. Эдгээр компани нь Нидерландын

155 Оксфам Интернэшнл, “Хар жагсаалт уу? Эсвэл халхавч үү? ЕХ-ны татварын диваажингийн үнэн бодит хар жагсаалт ямар байхын тухайд” (Blacklist or whitewash? What a real EU blacklist of tax havens should look like), 2017-11-*72. <https://www.oxfam.org/en/research/blacklist-or-whitewash-what-real-eu-blacklist-tax-havens-should-look>. Авсан 2017-12-08.

156 ЕХ-ны Зөвлөл, ЕХ-ноос татварын асуудлаар гаргасан “хамтран ажиллахаас татгалзсан этгээдийн жагсаалт”, 2017-12-05 (The EU list of non-cooperative jurisdictions for tax purposes, 5 December 2017), <http://www.consilium.europa.eu/media/31945/st15429en17.pdf>. Авсан 2017-12-06.

157 Оксфам Интернэшнл, “Хар жагсаалт уу? Эсвэл халхавч үү? ЕХ-ны татварын диваажингийн үнэн бодит хар жагсаалт ямар байхын тухайд” (Blacklist or whitewash? What a real EU blacklist of tax havens should look like), 2017-11-*72. <https://www.oxfam.org/en/research/blacklist-or-whitewash-what-real-eu-blacklist-tax-havens-should-look>. Авсан 2017-12-08.

хөрөнгө оруулалт болон давхар татварын хэлэлцээрийг ашиглах боломжтой байгаа нь гэрээ арилжихын сонгодог жишээ мөн. Нидерланд дахь хоёр охин компанийн нэгийг хоршооны хэлбэрээр бүртгүүлсэн нь тус улсын ногдол ашгийн татварыг зувчуулах боломжийг Рио Тинтод өгсөн байх магадлалтай бөгөөд энэхүү шуудангийн хайрцаг гэгч компанитай байх нь Оюу Толгойг зарах тохиолдолд өмч хөрөнгө борлуулсаны орлогын татвараас зайлсхийхэд ч хэрэг болох талтай. Нидерланд улсад аж ахуйн нэгжүүд шуудангийн хайрцаг төдий охин компания маш амархан байгуулж болдог нь тус улсын хоёр талт татварын гэрээ хэлэлцээрүүдийн таатай нөхцлүүдийг зүй бусаар ашиглах боломж гаргаж байна. Ийм учраас Нидерландын Засгийн газар дээрх бодитой байдлын болзлуудаа эргэн харж, гэрээг урвуулан ашиглахаас сэргийлсэн хаалт хамгааллыг бий болгох ёстой юм.

Люксембург улсын татварын алба нь татвар ногдох орлогыг үлэмж хэмжээгээр багасгах буюу Люксембургийн өмнө хүлээсэн татвар төлөх үүргээ бууруулахыг Рио Тинтод зөвшөөрсөн аж. Ингэснээр Люксембургийн засаг төр үндэстэн дамнасан корпорацуудад орлогоо Люксембургт байршуулж, татвар төлвөл зохих газар (тухайлбал Оюу Толгойн тохиолдолд Канадад) татвараас зайлсхийх хөшүүрэг өгч байгаа юм.

Рио Тинто нь татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх зорилгоор цуцлагдсан татварын хэлэлцээрүүд дэх суутгал татварыг бууруулах тухай заалтуудыг ашиглан Монголын өмнө хүлээсэн татварын үүргээ зүй бусаар бууруулж 232 сая ам.доллараар зувчуулжээ. Аль аль хэлэлцээр нь Оюу Толгойгоос Нидерланд, Люксембургт байрших Рио Тинтогийн шуудангийн хайрцаг төдий охин компаниуд руу шилжих хүүний төлбөрүүдэд ногдох суутгал татварыг 20%-иас 10% хүртэл бууруулахыг зөвшөөрсөн байв. Өмнө нь өгүүлсэнчлэн, Рио Тинтотой үүссэн маргаанд Монголын Засгийн газар барьц алдаж улмаар 2015 онд уг суутгал татварын хэмжээг цааш 6.6% хүртэл багасгахын зэрэгцээ буцаан хэрэглэхийг ямарваа утга бүхий үндэслэлгүйгээр зөвшөөрчээ. Энэ нь ялангуяа өнөөдөр зардлаа танаж бүсээ чангалах арга хэмжээ авахад хүрчихсэн байгаа Монгол орны хувьд үнэнхүү цээр шийтгэл юм. Тухайлбал, Монголын Засгийн газар алдагдсан энэ орлогоороо 2013–2015 онуудын хооронд боловсролд зарцуулсан төсвөө нугалж чадах байлаа.

Рио Тинто нь Оюу Толгойг санхүүжүүлэх нэрийдлээр Люксембург дэх шуудангийн хайрцаг төдий нэг ч ажилтангүй компанийг ашигласнаар Канадад төлвөл зохих 559 сая орчим ам.долларын компанийн орлогын татварыг 7 жилийн хугацаанд зувчуулж дөнгөжээ. Люксембургд Рио Тинто зөвхөн 89 сая ам. доллар бүхий 4.19%-ийн татварыг төлсөн аж. Өөрөөр хэлвэл, уг компани татвараас зайлсхийх схемээ хэрэглэснээр цэвэр 470 сая ам.долларын татварыг өгөхгүйгээр аргалжээ. Ийнхүү Рио Тинто нь Оюу Толгойг ажлуулсан 1 дэх шатны хугацаанд Монгол, Канадад зүй ёсоор төлвөл зохих сая сая ам. долларын татварыг төлөөгүй өнгөрсөн байна. Уурхайн 2 дахь шат болох асар том өргөтгөлийг 4.4 тэрбум ам.долларын багц зээлээр санхүүжүүлж байгаа нь энэхүү нийтийн мөнгө хөрөнгийг татвараас зайлсхийх тогтолцоогоор дамжуулан өнгөрөөх вий гэх асуудал гарч ирж байгаа юм.

Рио Тинто нь Оюу Толгойн хөрөнгө оруулалттай холбоотой нөхцөл шаардлагаа Монголын Засгийн Газраар тулган зөвшөөрүүлж чадсан нь хүү бүхий зээлээр санхүүжилтээ хийх болон орлогоосоо Монгол, Канадынх биш, харин Люксембургийн маш бага хувь хэмжээтэй татвар төлөх боломжуудаас завшив. Үүний улмаас Монгол улс нь зээл эргэн төлөгдтөл ашиг

хуваарилахгүй тул хоосон хоцорч байгаа юм. Оюу Толгойн өмчлөгч компаниуд болон МУ-ын ЗГ-ын хоорондох Хөрөнгө оруулалтын Гэрээний агуулга болон түүнийг байгуулан хэрэгжүүлэх үйл явцыг зүй бус шинж чанартай гэж үзэх үндэслэлтэй. Монголын Засгийн газар нь гэрээнүүд болон ажиллуулагч компаниудын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ард түмэндээ хүргээгүйн улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүнээс гарвал зохих үр шим нь олон нийтийн хараа хяналтаас гадуур үлдсэн байна.

Энэ илтгэлд өгүүлж буй татвараас зайлсхийх үйл ажиллагаа зэрэгт тавих олон нийтийн хараа хяналтыг чангатгах нэгэн арга бол “Орон тус бүрээр гаргах нийтэд нээлттэй тайлан”-гийн механизм¹⁵⁸ (ОТБГННТ) юм. Уг ОТБГНН тайланд компаниуд орлого болон төлсөн татвараа холбогдох орон тус бүрээр гаргаж мэдээлэх үүрэг хүлээдэг бөгөөд энэ нь тухайлбал Оюу Толгойн хувьд хэрэглэсэн татвар зувчуулах арга схемийг илчлэн тогтооход дэм болох байв. Рио Тинто нь Төлөгдсөн Татвар¹⁵⁹ хэмээх жилийн тайлан гаргадаг боловч эдгээр нь орлогыг Рио Тинтогийн ажиллаж буй орон бүрээр ялган салгаж харуулдаггүй учраас төлөгдсөн татварын хувь хэмжээний үнэн зөвийг хэлэх ямарч боломжгүй болдог. Цаашилбал, 2016 оны Төлөгдсөн Татвар тайланд Мовель SARL гэгч Люксембург дэх компанийг дурдаагүй өнгөрсөн байтал үүнийг тайлангаа орон бүрээр гаргах зарчмын дагуу мэдээлэх ёстой юм.¹⁶⁰ Охин компани бүрийн татвар, орлогыг байршил бүрээр жагсаасан дээрх тайланг Рио Тинто эсвэл Түркоиз Хилл Ресурсээс жил бүр гаргуулж авдаг байсан бол Оюу Толгойтой холбогдох татвар зувчуулалт эртнээс илрэх байв.

Оюу Толгойн цар хэмжээ, шавхагдах нөөц болон нийгэм-экологийн асар их үр нөлөө нь нийтийн хянуур хандлага болон уул уурхайн ихээхэн хэмжээний үйл ажиллагааг ийнхүү хохиролтой нөхцлөөр явуулж болох эсэх талаар өргөн нийтээр хэлэлцэхийг шаардаж байгаа юм. Суутгал татварыг удаа дараалан бууруулсан нь МУ-ын Засгийн газар уурхайн үйл ажиллагаанаас олох орлогыг үлэмж хэмжээгээр танаж, Оюу Толгойгоос зээлийнхээ хүүд төлж буй зардал нь уурхайн ашигт ажиллагаа болон Монгол орны хүртэх хувь хишгийг бууруулах магадлалтай. Цаашдын төлөв нь Оюу Толгойн ашиг орлогын дийлэнх хэсэг хүүний төлбөр хэлбэрээр Монголоос урван одож, Монголын Засгийн газар нь өчүүхэн бага ногдол ашиг, мөн компанийн татварыг олдвол авсан ба улс орны эрдэс баялгийг гадаадын хөрөнгө оруулагчдын ашгийн төлөө ухаж олборлосоноор харагдана. Бий болсон өнөөгийн нөхцөл байдалд Монголын ард түмэн Оюу Толгойгоос их юм хүртэхээргүй байна.

Монголын Засгийн газар дээрх нөхцөл шаардлагыг хүлээн зөвшөөрсөн нь асуудлын ноцтойг харуулж байгаа юм. Засгийн газрын шийдвэр гаж гарсаны шалтгаан нь улсын сул дорой эдийн засгийн байдал, засаглалын мэдэцгүй арга ажиллагаа аль эсвэл өөр хүчин зүйлс байсан эсэхийг тогтоох аргагүй юм. Алин ч бай, Монголын Засгийн газар улс орныг мөлжсөн тогтолцоог хүлээн зөвшөөрснөөрөө чухлаар холбогдох болж байгаа бөгөөд Монголын төр, ард түмэн энэхүү тогтолцоог эцэс болгох ёстой.

158 Европын Комисс, Орон тус бүрээр гаргах тайлан, огноогүй, https://ec.europa.eu/info/business-economy-euro/company-reporting-and-auditing/company-reporting/public-country-country-reporting_en. Авсан 2018-01-22.

159 Рио Тинто, Төлөгдсөн Татвар, огноогүй, <http://www.riotinto.com/investors/taxes-paid-22105.aspx>. Авсан 2018-01-22.

160 Rio Tinto, 2016 Taxes paid report, April 2017, http://www.riotinto.com/documents/RT_taxes_paid_in_2016.pdf. Авсан 2018-01-22.

Шигтгээ 4 Тус илтгэлийн талаарх Рио Тинтогийн хариу санал

Тус илтгэлд хариулахдаа¹⁶¹, Рио Тинто, Түркойз Хилл Ресурс нь ажлын байр байгуулах, мөн роялти болон НӨТ-ийн төлбөр төлөх зэргээр Монгол орны хувьд санхүүгийн нааштай нөлөө үзүүлсэн гэж мэдэгдэв. Эдгээр төлбөр нь бодитой боловч Монголын төсвийг санхүүжүүлэх, өсөлтийг тэтгэхэд шаардлагатай хууль ёсны орлогын албан татварыг орлохгүй бөгөөд Рио Тинтогийн татвараас зайлсхийх үйлдлийг болон улсад жам ёсоор төлөгдөх асар хэмжээний хөрөнгөөс татгалзахад хүргэсэн зүй бус Хөрөнгө оруулалтын гэрээг Монголын Засгийн газарт тулгаж хүлээн зөвшөөрүлсэнийг нь хаацайлах үндэслэл болохгүй.

Монгол, Канадын засаг Хөрөнгө оруулалтын гэрээ, татвар төлбөрийн төлөвлөгөө зэргийг хүлээн зөвшөөрсөн тул эдгээр нь зүй бус биш хэмээнээр дээрх хоёр компани хэлж байна. SOMO ийнхүү учирласантай зарчмын хувьд санал зөрнө. Яагаад гэвэл аль ч засгийн газрыг, тэр тусмаа энд яригдаж буй Монголын Засгийн газрыг ард түмний ашиг сонирхолд гэм хортой бүтэц тохироонд шахан оруулах магадлал нь үнэмлэхүй үзэгдэл юм.

Монголын Засгийн газар Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсгээ зурсан нь өөрийн ажил дадлыг эргэн харахыг шаардаж байгаа боловч энэ нь тус Гэрээний зүй бус шинж чанар болон тохиролцоог хэлэлцэн батлуулсан хөрөнгө оруулагчдыг цагаатгахгүй. Рио Тинто, Түркойз Хилл Ресурс нь SOMO-гоос шуудангийн хайрцаг төдий хэмээнээр үзсэн тэдний Нидерланд, Люксембург дахь охин компаниуд нь эрхзүй ба эдийн засгийн бодит этгээд мөн бөгөөд эрхэлж буй санхүүгийн үйл ажиллагаа нь хүн хүчний оролцоо шаарддаггүй учраас орон тооны ажилтангүй гэжээ. Ач холбогдлыг гагцхүү “эрхзүйн” гэсэн үгэнд өгвөл уг охин компаниудын талаар өгсөн тайлбарыг SOMO хүлээн авч болох юм. Энэ компаниуд эдийн засгийн бодит агуулгыг шаардсан хууль ёсны болзлыг хангасан болж, Нидерланд, Люксембург улсаас татварын хэлэлцээрүүдээр олгож буй бүхий л давуу нөхцлүүдээс завшсан хуулийн этгээдээр ажиллаж болж байгаа нь “бодит агуулгын болзол” гэгч нь сул байгаагаас шалтгаалсан асуудал юм. Эрхзүйн утгаар эдгээр компанийг шаардлага хангасан гэнэ. Гэвч нарийн харвал, тэрбумаар тоолох зээлийн мөнгө хөрөнгийг эргэлдүүлсэн компани бүртгэгдсэн газраа өөр аливаа үйл ажиллагаа явуулдаггүй, бас нэг ч ажилтангүй байх нь үнэнхүү гаж үзэгдэл юм. Бодит агуулгын болзол шаардлага нь цаасан дээр бүртгэл төдий этгээд бодит ертөнцөд асар хүч нөлөөтэйгээр оршин байхыг зөвшөөрч буйг нотолно.

Цаашилвал, Рио Тинто, Түркойз Хилл Ресурс нь “[Оюу Толгой] болон түүний хөрөнгө оруулагчид татварын ил тод байдлыг эрхэмлэдэг. Манай татвар төлбөрийн үйл ажиллагаа Монгол улсын хууль, олон улсын хэм хэмжээ, өөрийн хүлээсэн үүрэг зэрэгтэй бүрэн нийцсэнээр зогсохгүй Монгол орны эдийн засаг, хэтийн төлөвийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгаад бид итгэл төгс байна.” хэмээн тэмдэглэжээ.

161 SOMO-ийн хянах хүсэлтэд Рио Тинто болон Түркойз хилл ресурсын ирүүлсэн хариу и-мэйл, 2018-01-17-нд хүлээн авсан.

▫ Шигтгээ 4 Тус илтгэлийн талаарх Рио Тинтогийн хариу санал

Хоёр компани олон улсын аль хэм хэмжээ, хүлээсэн ямар үүргийг хэлж байгаа нь ойлгомжгүй. Харин Оюу Толгойд хамаарах татварын үйл ажиллагаа нь ЭЗХАХБ-аас гаргасан ба компанийн татварын талаарх дэлхийн магад хамгийн нөлөө бүхий Үндэстэн дамнасан компанийн удирдамж¹⁶²-ийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй. Жишээ нь, уг Удирдамжийн 11-р зүйлд “Компаниуд төлвөл зохих татвараа цагт нь төлж хүлээн авагч орны нийтийн төсөвт нэмэрлэх нь чухал. Тухайлбал, компаниуд ажиллаж буй орнуудынхаа татварын хууль тогтоомжийн үг үсэг, үзэл санааг чандлан сахих ёстой. Үзэл санааг чандлан сахих нь хууль тогтоомжийн зорилгыг танин биелүүлэхийг хэлнэ.”¹⁶³

Рио Тинто нь Монголд төлөх татвараа үлэмж хэмжээгээр багасгаж, өөртөө ашигтай гэрээ хэлэлцээрийг улсын Засгийн газарт тулган зөвшөөрүүлснээрээ Монголын татварын хууль тогтоомжийн үзэл санааг зөрчиж¹⁶⁴, улс орны санхүү төсвийн орчны шударга болон тогтвортой байдлыг хангах зорилгыг үл ойшоосон болно.

6.1 Зөвлөмжүүд

Эл илтгэлд өгүүлсэн татварыг бууруулах, татвараас зайлсхийх асуудлыг шийдвэрлэх хариуцлага Оюу Толгойд оролцоо бүхий бүх талд ногдоно. Цаашилбал, Европын Комиссоос саяхан гаргасан татварын диваажингуудын жагсаалт нь ялангуяа ядуу орнуудын татварыг олон улсын хэмжээнд зувчуулах явдалтай тэмцэхэд ЕХ нь үүргээ гүйцэтгэж чадаагүй, харин гишүүн орнууд нь татвар зувчуулахад хэрхэн чухал үүрэгтэйг харуулав. Рио Тинто нь татварын түрэмгий бодлого явуулах, эдийн засгийн давуу байдалдаа дөрөөлөн Монголын талыг дарамталж өөртөө ашигтай нөхцлийг бий болгохоос татгалзах онцгой үүрэгтэй. Хувьцаа эзэмшигчид нь компанитай хариуцлага тооцох ёстой.

Нидерландын Засгийн газар нь

- давхар татвараас хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулахыг Монголын Засгийн газартай ярьж байна.¹⁶⁵ Уул уурхайн компаниуд шинэчлэн байгуулагдах энэ хэлэлцээрийг урвуулан ашиглахгүй байхыг хангах ба Монголын татварын орлогыг хамгаалах үүднээс Нидерландын Засгийн газар нь роялти болон хүүний төлбөрт ногдох суутгал татварын хувь хэмжээг бууруулах байр сууринаас татгалзах.

162 OECD, Guidelines for Multinational Enterprises, 2011, <http://www.oecd.org/corporate/mne/>. Авсан 2017-12-06.

163 OECD, Guidelines for Multinational Enterprises, хуудас 60, 2011, <http://www.oecd.org/corporate/mne/>. Авсан 2017-12-06.

164 МУ-ын ЗГ, Татварын ерөнхий хууль, 20 May 2008, <http://www.eisourcebook.org/cms/February%202016/Mongolia%20General%20Law%20on%20Taxation%202008.pdf>. Авсан 2017-12-06.

165 165 Eurodad, Tax games: the race to the bottom, note 1037 in the report, <https://www.somo.nl/tax-games-the-race-to-the-bottom/>, авсан 2017-12-06.

- ▣ Рио Тинтод давуу нөхцөл олгож буйгаа зогсоож, Нидерландын татварын албанаас тус компанитай байгуулж ирсэн Үнэ шилжүүлэлтийн талаарх гэрээ болон Татвар шилжүүлэх жич журам зэргийг нийтэд нээлттэй болгож эдгээрийн татварт хамаатай нөлөөллийг нийтийн хяналтанд оруулах.
- ▣ бодит агуулгын болзлуудын хэрэгжилтийг сайжруулж, Европын комиссоос Татварын луйврын эсрэг мөрийн хөтөлбөртөө гэрээг урвуулан ашиглалтаас сэргийлэх талаар санал болгосон ерөнхий зохицуулалтуудыг нэвтрүүлэх.
- ▣ Оюу Толгойн хувьд тохиосон байж болзошгүй үндэстэн дамнасан компаниуд татварын давхар чөлөөлөлт хүртэхийг үл зөвшөөрсөн санхүү төсвийн бодлого явуулж, татварын давхар чөлөөлөлтийг зөвшөөрсөн татварын журам тогтоохоос татгалзах.

Люксембургийн Засгийн газар нь

- ▣ Оюу Толгойн санхүүжилтийн байдлыг хянан шалгах; Люксембургийн татварын алба татварын жич журам тогтоож өгсөн нь нотлогдвол энэхүү жич журам олгох бодлого, дадлаа өөрчлөн шинэчлэх. Ерөнхийдөө, Оюу Толгойн хувьд тохиолдсон байж магадтайг харгалзан, үндэстэн дамнасан компаниуд татварын давхар чөлөөлөлт хүртэхийг үл зөвшөөрсөн санхүү төсвийн бодлого явуулах.

Монгол улсын Засгийн газар нь

- ▣ Улсын бодлого тодорхойлох орчин болон орлогод сөргөөр нөлөөлхүйц хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрүүдийг гадаадын хөрөнгө оруулагчидтай байгуулахгүй байх. Монголын ард түмэн Оюу Толгойн уурхайгаас санхүүгийн үр шим хүртэхийг баталгаажуулах зорилгоор Рио Тинтотой байгуулсан Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг хянан засварлах.
- ▣ Давхар татвараас хамгаалах гэрээ хэлэлцээр байгуулах хандлага, байр сууриа эргэн харж, суутгал татварын хувь хэмжээг бууруулсан гэрээ байгуулахдаа татварын орлогын алдагдлаа сайтар бодолцсон байх. Энэ нь ялангуяа ГШХО-ын эх үүсвэр болсон ба энэхүү татвар бууруулалтаас ихээхэн хожих хөгжингүй орнууд оролцох тохиолдолд чухал ач холбогдолтой.
- ▣ Оюу Толгойн ил тод байдлыг тухайлбал Оюу Толгой ХХК-ийн жилийн тайлан тэнцэл, зэс, алт борлуулахад хэрэглэсэн шилжүүлсэн үнийн талаарх баримт бичгийг хэвлэн нийтлэх замаар хангах. Бие даасан хяналтын байгууллага бий болгох зэргээр Монголын уул уурхайн салбарын хүрээнд явагдах хэлэлцээ, байгуулагдах гэрээ хэлэлцээрүүд хууль болон Монголын ард түмний ашиг сонирхолд нийцсэн байхыг баталгаажуулах.
- ▣ Оюу Толгойн цар хэмжээ, шавхагдах нөөц болон уур амьгалын өөрчлөлтөөс улбаатай ган зудны улмаас угжирч байж болохуйц нийгэм-экологийн асар их үр нөлөөг харгалзах. Засгийн газар нь уул уурхайн ихээхэн хэмжээний үйл ажиллагааг ийм сүрхий хохиролтой нөхцлөөр явуулж болох эсэх талаар нийтийг хамарсан хэлэлцүүлгийг цаг алдалгүй эхлүүлэн дэмжих шаардлагатай байна.

Европын Холбоо нь

- “хамтран ажиллахаас татгалзсан татвар тогтоох бүрэн эрхт этгээд”-ийн жагсаалтаа эргэн хянаж, татварын диваажин болох ЕХ-ны гишүүн орнуудыг уг жагсаалтанд багтаах зорилгоор тэдгээрийг тодорхойлох, шинжлэн дүгнэх аргачлалаа өөрчлөн шинэчлэх
- Нидерланд, Люксембург болон Рио Тинтогийн охин компаниудын хооронд татварын жич журмуудыг байгуулсан байгаа эсэхийг шалгаж, эдгээр нь ЕХ-ны “төрийн дэмжлэг”-ийн журамтай нийцэж байгаа эсэхийг тогтоох.

Рио Тинто нь:

- Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол улсын Засгийн газартай хамтран хянан үзэх, улмаар дахин хэлэлцэн байгуулах үүрэг хүлээх. Үүгээр уурхайн орлогыг Монголын төртэй илүү шударгаар хуваалцах явдлыг хангана.
- Татвараас зайлсхийхээс татгалзаж, өнөөдөр хэрэглэж буй татвар зувчуулах бүхий л арга схемээ эцэс болгон үйл ажиллагаагаа санхүүгийн хариуцлагатай горимоор явуулж эхлэх.

Түркойз Хилл Ресурсын бусад хөрөнгө оруулагч нь

- Оюу Толгойн орлогын хуваарилалтыг компани болон Монгол улсын хороонд илүү тэгш болгохыг компаниас шахан шаардах. Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг хянан өөрчлөх нь энэ чиглэлд хийх эхний алхам болно.

Уул уурхайн татварууд

Оюу Толгойн хэрэг ба Рио Тинтогийн Монгол дахь татвар зувчуулалт

Өмнийн говийн бүсэд байршилтай Оюу Толгойн уурхай нь Монголын зэс, алтны тэргүүлэх уурхай мөн бөгөөд дэлхийд томоохонд тооцогдох зэс, алтны нөөцтэй төдийгүй уул уурхай, төмөрлөгийн салбарын түүхэнд нийтийн хөрөнгийн хамгийн том гэрээгээр санхүүжиж байгаа аж ахуй юм. Уурхай байрших газар нь нүүдэлчин малчид, түүнчлэн үлэмж тооны ховордсон ан амьтан, ургамлын нутаг аж. Уурхайн чухам эзэн хийгээд олборлолтыг гүйцэтгэгч нь татварын диваажингуудад бүртгэлтэй олон охин компани бүхий өмчлөлийн бүтцээрээ дамжуулан хяналтаа тавьж захирдаг Рио Тинто юм. МУ-ын Засгийн газар Оюу Толгой уурхайд цөөнх буюу 34%-ийн эзэмшилтэй. Оюу Толгой болон түүнийг ажиллуулагч Рио Тинто нь Монголын байгалийн баялгийн бодлогод голлох үүрэг гүйцэтгэх болжээ. Рио Тинтод хуулийн ямарваа өөрчлөлтөөс хамгаалагдсан татварын орчин нөхцөлийг олгосон Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ нь улс орны нөөц баялгад тавих нийтийн хяналтыг чангатгах шаардлагыг сонсогдуулах болсон аж.

Уг илтгэл нь Монголын ард түмэнд бага ач тустай, харин Рио Тинтогийн хувьд Нидерланд, Люксембург зэрэг дэлхийг толгойлсон татварын диваажингуудыг хамруулсан татвараас зайлсхийх тогтолцоог бий болгож өгсөн хөрөнгө оруулалтын гэрээг авч үзэж байгаа юм. Хүүтэй зээлээр хийж буй санхүүжилт болон орлогоос Монгол, Канадынх биш, харин Люксембургийн маш бага хувь хэмжээтэй татвар төлж ирсэн нь Канад, Монголоос 700 сая ам.долларын татвар зувчуулах боломжийг Рио Тинтод өгчээ. Суутгал татварыг олон дахин бууруулсан нь Монгол улсын уурхайгаас авах орлогыг үлэмж хэмжээгээр танаж, зээлд төлж буй хүү нь ашигт ажиллагаа, ногдол ашгийг ойрын төлөвт хязгаарлах болж байна.

Оюу Толгойн цар хэмжээ, шавхагдах нөөц болон нийгэм-экологийн асар их үр нөлөө нь нийтийн хянуур хандлага болон уул уурхайн ихээхэн хэмжээний үйл ажиллагааг ийнхүү хохиролтой нөхцлөөр явуулж болох эсэх талаар өргөн нийтээр хэлэлцэхийг шаардаж байгаа юм.

